



АГУУЛГА

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

- 1.1 Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт
- 1.2 Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт
- 1.3 Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт
- 1.4 Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт
- 1.5 Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлт

ХОЁР. БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ

- 2.1 Монгол Улсын Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт
- 2.2 Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт
- 2.3 Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилт

ГУРАВ. БАЙГУУЛЛАГЫН НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

- 3.1 Байгууллагын ил тод байдал
- 3.2 Шилэн дансны хөтлөлт
- 3.3 Шударга байдлын түвшин
- 3.4 Хэрэглэгчийн үнэлгээ

ДӨРӨВ. МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН БАРИМТ БИЧИГТ ТУССАН ЗАСГИЙН ГАЗРЫН ТЭРГҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДОЛТОЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

- 4.1 Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээг үнэлэх шалгуур үзүүлэлтийн биелэлт

ДӨРӨВ. БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН



АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГИЙН ХУРААНГУЙ

- ✚ Аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүн 2023 оны жилийн эцсийн байдлаар 630.1 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 14.6 хувиар, нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн 10.3 сая төгрөгт хүрч, өмнөх оноос 16 хувиар тус тус өссөн байна.
- ✚ Улсын төсөвт 3.1 тэрбум төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 112.7 хувь, аймгийн төсөвт 30.4 тэрбум төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 108.0 хувь, сумын төсөвт 28.6 тэрбум төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 113.8 хувиар, нийт төсвийн орлогын төлөвлөгөөг 110.7 хувьтай биелүүлсэн.
- ✚ “Орон нутагт үр дүнд суурилсан нэгдсэн удирдлагыг хэвшүүлэх нь” сэдэвт дэмжих хөтөлбөрт аймгийн Засаг даргын Тамгын газрын “Bulgan team” баг амжилттай оролцож, 2 дугаар байрт шалгарсан.
- ✚ Эрүүл мэндийн салбарт 2024 онд улс, орон нутгийн төсөв, хандив тусламжаар 7.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж, тоног төхөөрөмжийн стандарт хангалт 92.4 хувьд хүрсэн байна.
- ✚ Хүн амын дунд зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг оношилгоонд хамрагдвал зохих иргэдийн 43.2 хувийг хамруулсан нь 2023 оны жилийн эцсийн хамрагдалтаас 2.2 хувиар өссөн байна.
- ✚ Эмч, эмнэлгийн мэргэжилтний мэргэшил, ур чадварыг сайжруулах чиглэлээр төгсөлтийн дараах үндсэн мэргэшлээр 16 эмч, сувилагч, тусгай мэргэжилтэн, өндөр хөгжилтэй оронд урт болон богино хугацааны сургалтад 9 эмч, мэргэжилтэн хамрагдаж мэргэжил, ур чадвараа дээшлүүллээ.
- ✚ Аймгийн 7 суманд ажиллаж байгаа 6 эмч, эмнэлгийн мэргэжилтэн шинэ орон сууцаар, Нэгдсэн эмнэлгийн Халдварт сүрьеэгийн тасгийн хуучин барилгыг амьдрах зориулалтаар засварлан 6 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтныг амьдрах байраар ханган нийгмийн баталгааг сайжруулснаар эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хангалт 88.5 хувьтай байна.
- ✚ Хөдөөгийн хүн амд нийгмийн суурь үйлчилгээг нэг дороос хурдан, шуурхай, чанартай хүргэх зорилгоор "Хүрч үйлчилье" арга хэмжээг 8 сум, 1 тосгонд зохион байгуулж, аймгийн Засаг даргын нэрэмжит нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгт 3101 иргэн, амны хөндийн үзлэг, оношилгоонд 0-17 насны 1550 хүүхдийг хамруулж, 3100 иргэнд мэдээлэл хүргэж, зорилтот бүлгийн 160 өрхөд нөхцөл байдлын үнэлгээ хийсэн.



- ✚ 2024 онд боловсролын салбарт нийт 11.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэнээс улсын төсвөөс 10.9 тэрбум, орон нутгийн төсвөөс 3.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж тоног төхөөрөмж, тоглоомын хангалт өмнөх оноос 10.0 хувиар өсөж 75.0 хувьд хүрсэн байна.
- ✚ 2023-2024 оны хичээлийн жилд "Шинэ багш" хөтөлбөрийн хүрээнд Багшийн хувь хүний хөгжлийн сургалтыг олон талт хэлбэрээр зохион байгуулж, 10 гаруй чиглэлийн 500 гаруй цахим болон танхим хосолсон сургалтад давхардсан тоогоор 15000 орчим багш, удирдах ажилтан, албан хаагчид, эцэг, эх, суралцагчийг хамруулав.
- ✚ "Сургуульд суурилсан менежментийн загвар"-ыг Боловсролын яам, Боловсролын ерөнхий газар, "Шинэ Монгол төв"-тэй хамтран үе шаттай хэрэгжүүлж, аймгийн хэмжээнд 16 ерөнхий боловсролын сургууль, 1 цэцэрлэгийг хамруулан сургуулийн менежментийн 3-4 загварыг туршин хэрэгжүүлснээр удирдлагын манлайлал, менежмент 2.3 хувь, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт 4 хувь, хүүхдийн хөгжил хамгаалал 10.3 хувь ахисан амжилттай байна.
- ✚ Элсэлтийн ерөнхий шалгалтад амжилт үзүүлсэн болон улс бүсийн тэмцээнд амжилттай оролцсон багш нарт 10.5 сая төгрөгийн урамшуулал, дэмжлэгийг үзүүлсэн.
- ✚ Хутаг-Өндөр, Тэшиг, Сайхан сум, Хялганат тосгонд боловсролын салбарын 15 хаагчийн нийгмийн баталгааг шийдэж, орон сууцаар хангалаа.
- ✚ "Шинэ ирээдүй" хөтөлбөрийн хүрээнд математикийн судлагдахуун 5.1 хувиар, англи хэлний судлагдахуун 4.4 хувиар суурь түвшнээс тус тус өсөж, сурлагын хоцрогдол нөхөх, арилгах цогц төлөвлөгөөний биелэлт 72.1 хувь буюу улсын дунджаас дээгүүр үнэлэгдлээ.
- ✚ Аймгийн Засаг даргын нэрэмжит тэтгэлэгт хөтөлбөрийг 4 дэх жилдээ хэрэгжүүлэн 2024 онд 344 суралцагчийг хамруулан 1443.3 сая төгрөгийн сургалтын төлбөрийн тэтгэлэг, дэмжлэг, урамшуулал олгож, тэтгэлэгт хамрагдсан хүүхдийн тоо өмнөх оноос 3.3 дахин өссөн байна.
- ✚ Үндэсний бичиг үсгийг түгээн дэлгэрүүлэх, бүх нийтийн хэрэглээ болгох "Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2024" арга хэмжээг "Үндэсний бичиг соёлоо эрхэмлэн дээдэлье" уриатайгаар зохион байгуулав.
- ✚ 2024 онд улс, бүсийн болон аймгийн чанартай 34 төрлийн уралдаан тэмцээнийг амжилттай зохион байгуулан 25000 орчим иргэдийг хамруулан орон нутгийн төсвөөс 200.0 сая төгрөг зарцууллаа.



- ✚ “Биеийн тамир, спортыг хөгжүүлэх хөтөлбөр”-т орон нутгийн төсвөөс 150.0 сая төгрөг, “Өсвөрийн шигшээ багийг бэлтгэх хөтөлбөр”-т 90.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж, улсын чанартай 3 төрлийн тэмцээн уралдааныг аймаг орон нутагтаа амжилттай зохион байгууллаа.
- ✚ Гадаад орнуудтай хамтын ажиллагааг сайжруулах, тамирчдын ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор 48.3 сая төгрөгийн дэмжлэг үзүүлснээр Тайланд улсад зохион байгуулагдсан модон барилдааны дэлхийн аварга шалгаруулах тэмцээн болон Хөнгөн атлетикийн Ази тивийн аварга шалгаруулах тэмцээнд 1 алт, 1 мөнгө, “Парис-2024” паралимпын наадмын хөнгөн атлетикийн бөөрөнцөг түлхэлтийн /F40 ангилал/ төрөлд оролцсон ОУХМ Ц.Баттулга мөнгөн медаль хүртсэн амжилт үзүүлээ.
- ✚ Үндэсний спортыг хөгжүүлэх зорилгоор Булган аймгийн харьяат “Таван аваргын нэрэмжит 128 бөхийн барилдаан”, “Мөнгөн өвөл-2024” арга хэмжээ, “Харгалын хүчтэн” үндэсний бөхийн өсвөр үе, залуучуудын цомын төлөөх нээлттэй тэмцээнүүдийг орон нутгийн төсвийн 49.9 сая төгрөгөөр амжилттай зохион байгууллаа.
- ✚ Иргэд олон нийтийг соён гэгээрүүлэх, бүх нийтэд соёлын боловсрол олгох, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, өв соёлыг түгээн дэлгэрүүлэх ажлын хүрээнд 169 уралдаан тэмцээн, 282 тоглолт, 30388 үзвэр үйлчилгээ, бусад арга хэмжээ зохион байгуулж, давхардсан тоогоор 281008 хүнд соёлын үйлчилгээг хүргэлээ. Тус ажлын хүрээнд зохион байгуулсан үйл ажиллагааны тоо суурь түвшинтэй харьцуулахад 0.5 хувиар, үйл ажиллагаанд оролцогчдын тоо 0.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна.
- ✚ Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт хамгаалалтыг сайжруулах зорилгоор улс, аймгийн хамгаалалттай 53 дурсгалаас 2024 оны жилийн эцсийн байдлаар 41 дурсгалыг хашаажуулан хамгаалсан.
- ✚ Аймгийн соёл урлагийн салбарт ажиллаж байгаа 170 ажилтнаас 116 нь буюу 68.2 хувь нь мэргэжлийн ажилтан байна. Соёлын байгууллагуудад ажиллаж буй мэргэжлийн бус 54 ажилтнаас 9 албан хаагчийг эчнээгээр суралцуулан мэргэшүүлэхэд дэмжлэг үзүүлэн ажиллалаа.
- ✚ 2024 онд соёл, урлагийн салбарын барилга байгууламжийг шинээр барих, их засвар хийх, өргөтгөх ажлуудад орон нутгийн төсвөөс 1.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тусгаж, Орхон сумын соёлын төвийн их засвар, Аймгийн музейн их засвар, Хангал сумын соёлын төвийн тайз, орон нутаг судлах



- танхимын засвар, Тэшиг сумын соёлын төвийн ариун цэврийн байгууламжийн засварыг 100 хувь хийж гүйцэтгэлээ.
- ✚ “Алтаргана 2024” олон улсын XV наадамд соёл, спорт, хэвлэл мэдээллийн чиглэлээр зохион байгуулагдсан 22 төрлийн тэмцээн уралдаанд гадаад, дотоодын 1700 гаруй иргэд авьяас, мэдлэг, ур чадвараа сорин өрсөлдлөө. Тус наадмын тэмцээн уралдаан болон соёлын цогц арга хэмжээг 60 мянга орчим иргэд, жуулчид үзэж сонирхлоо.
 - ✚ Аймгийн хэмжээнд хүн амын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, ажилгүйдлийн түвшнийг бууруулах чиглэлээр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсөл, хөтөлбөрт 1735 иргэнийг хамруулан, 2.5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг зарцуулж, иргэдийн аж ахуй эрхлэлтийг дэмжсэн.
 - ✚ Бүтээн байгуулалт, төсөл хөтөлбөрийн хүрээнд төрийн болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар 904 шинэ ажлын байрыг бий болгож, сул чөлөөтэй ажлын байранд 1165 иргэнийг зуучилснаар ажилгүйдлийн түвшин 2024 оны 4 дүгээр улирлын байдлаар 1.5 хувь болсон нь өнгөрсөн оны мөн үеэс 5.7 пунктээр буурсан эерэг үзүүлэлттэй байна.
 - ✚ “ЗӨВ ГЭР БҮЛ-20” арга хэмжээг хэрэгжүүлэн зорилтот өрхийн гишүүдээс давхардсан тоогоор 317 иргэнийг ажлын байртай болгон, мэргэжил олгох сургалтад 33, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн малжуулах болон санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд 39 иргэнийг хамруулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжин ажилласны үр дүнд хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг, халамж авагч иргэдийн тоо өмнөх оноос 403 иргэнээр буурсан.
 - ✚ 2024 онд малчин болон сайн дураар даатгуулагчийн нийгмийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлж, төлөвлөгөөний биелэлтийг 130 хувиар биелүүлсэн.
 - ✚ Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 408.0 сая, халамж, хамгаалал, хөгжил оролцоог дэмжих зардалд орон нутгийн төсвөөс 102.0 сая, нийт 510.0 сая төгрөгийн төсвийг зарцуулж, зорилтот бүлгийн иргэдийн хөгжлийг дэмжив.
 - ✚ Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилсан сэргийлэх гэр бүлийн гишүүн бүрт олгох сургалт нөлөөллийн арга хэмжээ, нэрэмжит аянуудыг аймгийн хэмжээнд зохион байгуулж, 13351 иргэнийг хамруулж, нийт өрхийн 68 хувьд хүрч ажилласан.



- ✚ Эрсдэлт нөхцөл дэх хүүхдэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх 9 удаагийн үйл ажиллагааг зохион байгуулж, давхардсан тоогоор 712 хүүхдэд шаардлагатай тусламж дэмжлэг үзүүлж, 100 хувь хүрч үйлчилсэн.
- ✚ Хүн амын бүлгүүдийн хөгжил хамгааллыг сайжруулах зорилгоор хөгжлийн төвүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлэн, хүчирхийлэлд өртсөн хүүхэд, эмэгтэйчүүд, иргэдэд үйлчлэх нэг цэгийн үйлчилгээний төв болох түр хамгаалах байрны үйлчилгээнд шаардлагатай хатуу зөөлөн эдлэлээр хангаж, 2024 оны жилийн эцсийн байдлаар 53 иргэнд үйлчилгээ үзүүлэв.
- ✚ 2024 онд улс, орон нутгийн төсөв, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын хөрөнгө оруулалтаар "Жаргалант" хүүхдийн зусланг ашиглалтад оруулан тоног төхөөрөмжөөр хангаж, хүүхэд хөгжлийн зуны хөтөлбөрийг хэрэгжүүлэн 2 ээлж бүхий 168 хүүхдийг хүлээн авч ажилласан.
- ✚ Орон нутгийн түвшин дэх нийгмийн бүх харилцаанд жендэрийн тэгш байдлыг хангах чиглэлээр 4 зорилт, 20 ажлыг төлөвлөн 91.6 хувьтай гүйцэтгэв.
- ✚ Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт нэмэгдэж, үйлдвэрлэл үйлчилгээний салбар нь аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүний 39.64 хувийг буюу 250.1 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад үйлдвэрлэл 16 хувь, үйлчилгээ 40.8 хувиар өссөн дүнтэй байна.
- ✚ Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сангаас 10 төсөлд 920.0 сая, хоршоо хөгжүүлэх сангаас 19 хоршоонд 705.0 сая, "Хүнсний хувьсгал"-ын зээлд 3 төсөл 380.0 сая, "Шинэ хоршоо"-ны хүрээнд 1390 малчин 51.4 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамрагдаж, "Зээлийн батлан даалтын сан"-гаас 32 иргэн 678.3 сая төгрөгийн батлан даалтад тус тус хамрагдаж, нийт 1454 иргэн, аж ахуйн нэгж 54083.3 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамрагдав.
- ✚ "Гурванборхууд" ХХК-ийн "Арвайн гурил", "Сүргийн нуга" ХХК-ийн "Зөгийн бал" бүтээгдэхүүн органик бүтээгдэхүүнээр баталгаажиж, татварын 100 хувийн хөнгөлөлт эдэлж байна.
- ✚ Хоногт 10-15 тн сүү боловсруулах хүчин чадалтай "Мээжийн сүү" үйлдвэр 641635 л сүү цуглуулж, 581468 л сүү урамшуулалд хамруулж, 423 тн сүү сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 25 ажлын байрыг хадгалж ажиллав.
- ✚ "Хутаг-Өндөр мах маркет" ХХК 495 тн мах экспортод нийлүүлж, мал сүргийг эдийн засгийн эргэлтэд оруулахад хувь нэмэр оруулав.



- ✚ “Хүнсний хувьсгал”-ын хүрээнд хүнс, гурилан бүтээгдэхүүний үйлдвэрлэл цехүүд хөнгөлөлттэй зээлд хамрагдаж, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийж, бүтээмжээ 2 дахин нэмэгдүүлэв.
- ✚ Хөдөө аж ахуйн салбарт улсын төсвийн 4.4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж, хамгаалагдсан хөрсний үйлдвэрлэл 34760 м.кв-аар нэмэгдэж, аймгийн төвд хүлэмжийн агро парк байгуулагдах нөхцөл бүрдлээ.
- ✚ Улсын болон орон нутгийн төсвийн 443.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 17 худаг шинээр гаргаж, бэлчээрийн усан хангамжийг 23.8 мянган га талбайгаар нэмэгдүүлснээр 63.0 мянган толгой малыг усжуулсан байна.
- ✚ Ойн хөнөөлт хортон шавьжны судалгааны ажлыг 919200 га талбайд хийж, ойн хортны тэмцлийн ажлыг 23500 га талбайд байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын 759.7 сая төгрөгөөр хийж гүйцэтгэлээ.
- ✚ “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Орхон, Хутаг-Өндөр, Бугат суманд 20 га талбайд ойжуулалт хийж, аймгийн хэмжээнд 466379 ширхэг мод тарьж ургуулсан.
- ✚ 2024 онд "Хангинахын шугуйн шагайн тойром", "Алтаргана 2024" олон улсын наадам, "АЙРАГ НААДАМ", "Airagday" зэрэг эвент арга хэмжээг зохион байгуулж, давхардсан тоогоор гадаадын 19360, дотоодын 267820 орчим аялагчид үзэж сонирхохоор зорин ирсэн байна. Дээрх арга хэмжээнүүдэд оролцогчдын тоо өмнөх онтой харьцуулахад 13.0 хувиар өссөн дүнтэй байна.
- ✚ Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд 37 төсөл арга хэмжээнд улсын комисс ажиллаж байнгын ашиглалтад оруулсан.
- ✚ 2024 онд аймгийн хэмжээнд 30844 иргэнд тоон гарын үсэг олгосон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 34.5 хувиар өссөн байна.
- ✚ Төрийн албаны ерөнхий шалгалтыг 4 удаа зохион байгуулж, төрийн албаны ерөнхий шалгалтын дүнгээр 91 иргэн нөөцөд бүртгэгдсэн.
- ✚ Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагч, төрийн захиргааны гүйцэтгэх албан тушаалын 145 сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалт, тусгай шалгалтыг 8 удаа зохион байгуулсан.
- ✚ 2024 онд давхардсан тоогоор 11071 албан хаагч Төрийн албаны тухай хууль, тогтоомжийн хүрээнд мэргэшүүлэх багц цагийн болон бусад чадавхжуулах сургалтад хамрагдсан. Мөн боловсролын зэргээ ахиулахаар 14 албан хаагч суралцаж байна.

-----oOo-----



**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН
НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ**

1.1 Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт

Булган аймгийн Засаг даргын Тамгын газар нь 2024 оны жилийн эцсийн байдлаар аймгийн Засаг даргад хэрэгжүүлж ажиллахаар үүрэг болгосон 153 шийдвэрийн 261 заалтыг хяналтад авч, холбогдох журмыг баримтлан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, аймгийн Засаг даргын удирдлагын багийн хурлаар хэлэлцүүлэн Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нэгдсэн сан (unelgee.gov.mn)-д хугацаанд нь байршуулж, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлсэн.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр хяналтад авсан 153 шийдвэрийн 261 заалтын 209 (80.1 хувь) нь бүрэн хэрэгжсэн, 44 (16.8 хувь) нь хэрэгжих шатанд, 4 (1.5 хувь) нь хэрэгжилт хангалтгүй, 1 заалт (0.3 хувь) нь хэрэгжээгүй, 3 (1.1 хувь) нь хэрэгжилт тооцох хугацаа болоогүй заалт байгаа ба биелэлтийн дүнг дунджаар авч үзвэл **93.41** хувьтай буюу **4.67** оноогоор үнэллээ. (Хүснэгт 1)

Хүснэгт 1. Тогтоол шийдвэрийн биелэлтийн дүн


2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР ХЭРЭГЖИЛТИЙГ ТООЦОХ ШИЙДВЭРИЙН ДҮНГ НЭГТГЭХ ХҮСНЭГТ													
Булган		12/20/2024											
		Нийт	Тогтоол, шийдвэр										
			Үүнээс										
			Нийт	Үүнээс									
	УИХ-ын тогтоол	УИХ-ын байнгын хорооны тогтоол		Ерөнхийлөгчийн зарлиг	Монгол улсын хууль	Засгийн газрын тогтоол	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	Засгийн газрын албан даалгавар	ҮАБЗ-ийн зөвлөмж	Ерөнхий сайдын захирамж	ҮАБЗ-ийн хуралдааны тэмдэглэл		
Хяналтад авсан нийт шийдвэрийн тоо		153	153	13	18	5	8	56	44	3	6	0	0
Хяналтад авсан нийт зүйл, заалтын тоо		261	261	22	43	11	27	80	65	3	10	0	0
Үүнээс	Бүрэн хэрэгжсэн 100 хувь /90-100/	209	209	19	37	10	23	62	50	1	7	0	0
	Хэрэгжих шатанд 70.0 хувь /50-89/	44	44	2	6	1	3	16	12	2	2	0	0
	Хэрэгжилт хангалтгүй 30.0 хувь /10-49/	4	4	0	0	0	1	1	1	0	1	0	0
	Хэрэгжээгүй 0.0 хувь /0-9/	1	1	0	0	0	0	0	1	0	0	0	0
	Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй	4	4	1	1	0	0	1	1	0	0	0	0
Биелэлтийн дүн /хувь/		93.4	93.4	97.1	95.8	97.3	94.1	93.0	91.7	80.0	87.0	#DIV/0!	#DIV/0!

Дээрх хүснэгтээс харахад тогтоол шийдвэрийн хэрэгжилт сайн буюу нийт хяналтад авсан шийдвэрүүдийн 80.1 хувь нь бүрэн хэрэгжиж үр дүнд хүрсэн, харин 16.8 хувь нь хэрэгжих шатанд буюу зохион байгуулалтын үйл ажиллагаа хийгдэж байгаа, харин 1.1 хувь нь аймагт хамааралгүй шийдвэрийн заалтууд багтаж байна. Хөрөнгийн эх үүсвэр, болон удирдлага зохион байгуулалтаас шалтгаалж 4 заалт хэрэгжилт хангалтгүй, 1 заалт хэрэгжээгүй байна.



Тогтоол шийдвэрийн биелэлтийг нарийвчлан авч үзвэл Монгол Улсын 8 хуулийн 27 заалт 94.07 хувь, УИХ-ын 13 тогтоолын 22 заалт 97.14 хувь, УИХ-ын байнгын хорооны 18 тогтоолын 43 заалт 95.81 хувь, Ерөнхийлөгчийн 5 зарлигийн 11 заалт 97.27 хувь, Засгийн газрын 56 тогтоолын 80 заалт 93.04 хувь, Засгийн газрын хуралдааны 44 тэмдэглэлийн 65 заалт 91.72 хувь, Засгийн газрын 3 албан даалгаврын 3 заалт 80.0 хувь, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 6 зөвлөмжийн 10 заалт 87.0 хувьтай тус тус хэрэгжжээ. (График 1)

График 1. Тогтоол шийдвэрийн биелэлт (шийдвэрийн ангиллаар)



Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтэд тэр дундаа Монгол Улсын хууль болон Улсын Их хурлын тогтоолуудын биелэлтийг хангах зорилгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд нэлээдгүй үр дүнд хүрсэн байна гэж үзлээ.

Баяннуур сумын “Баян” нуурыг сэргээх ажлыг улсын төсвийн 556.3 сая төгрөгийн хөрөнгөөр “Усны барилга” ХХК шалгарч, Туул голоос 3.2 км урттай далд шугам, 3.4 км ил далангаар ус татаж, 120 м.кв талбай бүхий ус хуримтлуулах усан сан, толгойн барилга, ус чиглүүлэх барилга, өргөх станцуудыг тус тус барьж байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна.

Аймгийн аюулгүйн нөөцөд 100 тн өвс, 40 тн тэжээл бэлтгэхээс 56 тн тэжээл бэлтгэж, 202 тн өвс бэлтгэсэн. Сумын аюулгүйн нөөцөд 640 тн өвс, 480 тн тэжээл бэлтгэхээр төлөвлөж, 709 тн өвс, 323.5 тн тэжээл бэлтгэсэн.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, “ХААК” ТӨХК-ийн Булган салбараас хуваарилсан 300 тн тэжээлийн буудайг Баяннуур, Дашинчилэн, Рашаант, Гурванбулаг, Могод, Хишиг-Өндөр, Бүрэгхангай, Сайхан, Баян-Агт, Хангал, Орхон, Булган сумдад олгосон. Улсын онцгой комиссоос нийлүүлж буй 450 тн тэжээлийг Сэлэнгэ аймгаас татан авч, Баян-Агт, Баяннуур, Бүрэгхангай,



Гурванбулаг, Дашинчилэн, Могод, Орхон, Рашаант, Сайхан, Хангал, Хишиг-Өндөр сумдад тус тус нийлүүлсэн. Нийт аймгийн 750 тн тэжээлийг татан авахад 50.0 сая төгрөгийг зарцуулав.

Аймгийн хэмжээнд Улсын онцгой комиссын үүрэг даалгавраар төрийн цэргийн байгууллагуудын 8 нэгж техник, 16 албан хаагч, орон нутгийн 11 техник хэрэгсэл, 71 албан хаагч Баяннуур, Гурванбулаг, Дашинчилэн, Рашаант, Сайхан, Могод суманд 1795 км хаагдсан зам давааг чөлөөлсөн.

“Малчдадаа тусалъя” аяны хүрээнд Гандантэгчэнлэн хийд, Наро Банчэн Гэгээнтний үүсгэн байгуулсан "Нароба институт", Сүсэгтэн олны хандиваас 12.0 тн хорголжин тэжээл, 450 боодол өвс, Улаан загалмайн хорооноос 100 малчин өрхөд мөнгөн тусламж, малын эрдэс тэжээлийн багц, Гадаад харилцааны яамнаас 2 сумын 100 малчин өрхөд хүнсний болон малын эрдэс тэжээлийн багц, Дэлхийн зөн олон улсын байгууллага, НҮБ-аас 16 сумын 276 малчин өрхөд мөнгөн тусламж ирүүлснийг өвөлжилт, хаваржилт хүндэрсэн урд бүсийн Рашаант, Дашинчилэн, Баяннуур, Бүрэгхангай, Сайхан, Могод, Гурванбулаг, Хишиг-Өндөр сумын малчдад тус тус олгосон. Мөн аймгийн Хөгжимт жүжгийн театрт хамтран “Малчдадаа тусалъя” хандивын тоглолтыг зохион байгуулж, цугларсан хандиваар малчдад эрдэс тэжээлийн багцыг олгосон.

Аймгийн Засаг даргын 2024 оны А/84 дүгээр захирамжаар 02 дугаар сарын 15-ны өдрөөс 05 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжсэн. Захирамжийн хүрээнд аймгийн хэмжээнд Шуурхай штабуудыг байгуулж, бэлэн байдлын төлөвлөгөөг гарган ажиллаж, цаг тухай бүр мэдээ мэдээллийг Улсын онцгой комисст хүргүүлэн ажилласан.

Хөдөөгийн сэргэлтийн бодлогын хүрээнд аймаг орон нутагт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар 25 айлын 2 орон сууц, 20 айлын орон сууц ашиглалтад орсон. 2024 оны жилийн эцсийн байдлаар манай аймагт 150 иргэн шилжин ирсэн байна.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийн явцад хагас, бүтэн жилээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, аймгийн Засаг даргын Удирдлагын багийн хурлаар хэлэлцүүлэн хэрэгжилт удааширсан, эрчимжүүлэх шаардлагатай ажлуудыг илрүүлэн, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас ирүүлсэн дүгнэлт, зөвлөмжийн дагуу гүйцэтгэлийг сайжруулан ажилласнаар тайлангийн чанар сайжирсан эерэг үр дүн гарсан байна.

Үнэлгээгээр гарсан хэрэгжилт удаашралтай шийдвэрүүдийн зүйл, заалт нэг бүрийн биелэлтийг эрчимжүүлэх, удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллах талаар сум, байгууллагуудад зөвлөмж өгч ажилласан.



1.2 Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнөөс 2024 онд Булган аймагт 16 зорилтын 19 арга хэмжээг хариуцуулж, Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан (unelgee.gov.mn)-д байршуулсныг хяналтад авч, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв. (Хүснэгт 2)

Хүснэгт 2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт

		Эдийн засгийн бодлого	Засаглалын бодлого	Ногоон хөгжлийн бодлого	Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого
Хяналтад авсан нийт зорилтын тоо	16	5	2	3	6
Хяналтад авсан нийт арга хэмжээний тоо	19	6	4	3	6
100 хувь	12	3	2	3	4
90.0 хувь	3	1	0	0	2
70.0 хувь	2	1	1	0	0
50.0 хувь	0	0	0	0	0
30.0 хувь	1	1	0	0	0
0 хувь	0	0	0	0	0
Хамааралгүй	1	0	1	0	0
Хэрэгжилтийн хувь	91.1	81.7	90.0	100	96.7


Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт 2024 оны эхний хагас жилийн байдлаар (өссөн дүнгээр) 91.1 хувь буюу “тодорхой үр дүнд хүрсэн” байна. Эдгээр ажлуудыг хэрэгжүүлэхэд 2021-2024 онд улс, орон нутгийн төсөв, хувийн хэвшлийн 55536.7 сая төгрөг зарцуулжээ.

2021-2024 онд санхүүжилт нь шийдвэрлэгдсэн арга хэмжээнүүд төлөвлөгөөний дагуу үр дүнтэй хэрэгжиж, арга хэмжээнүүдийн 94.4 хувь нь үр дүнтэй болон тодорхой үр дүнд хүрсэн байна.

Эдийн засгийн бодлогын 5 зорилтын 6 арга хэмжээ 81.7 хувь, засаглалын бодлогын 2 зорилтын 4 арга хэмжээ 90.0 хувь, ногоон хөгжлийн бодлогын 3 зорилтын 3 арга хэмжээ 100 хувь, нийслэл ба бүс орон нутгийн хөгжлийн бодлогын 6 зорилтын 6 арга хэмжээ 96.7 хувьтай тус тус хэрэгжлээ. Үүнээс 12 арга хэмжээ 100 хувь, 3 арга хэмжээ 90.0 хувь, 2 арга хэмжээ 70.0 хувь, 1 арга хэмжээ 30.0 хувийн хэрэгжилттэй гарлаа. Мөн 1 арга хэмжээ аймагт хамааралгүй байна. (График 2)



График 2.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт



Тус төлөвлөгөөнөөс төсөв хөрөнгөгүйгээс шалтгаалан хэрэгжилт нь удааширч байгаа 1 арга хэмжээг 30.0 хувиар дүгнэж, 1 арга хэмжээ манай аймагт хамааралгүй тул хяналтаас хасуулах саналыг Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлсэн.

Хөдөө сумдад ажиллаж амьдарч буй төрийн албан хаагчдын амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор 2022-2024 онд орон нутгийн төсвийн 860.0 сая төгрөгөөр Сайхан, Тэшиг, Хутаг-Өндөр сум, Хангал сумын Хялганат тосгонд 14 айлын орон сууцны барилга барьж ашиглалтад оруулав. Мөн 2020-2024 онд суманд ажиллаж буй 85 багш, эмч нарыг дотоод нөөц бололцоонд тулгуурлан амьдрах байраар хангасан. Дашинчилэн сум орон нутгийн хөгжлийн сангийн 10.0 сая төгрөгөөр төрийн өмчийн 3 орон сууцыг засварлаж, 7 төрийн албан хаагчийг орон сууцаар, Бүрэгхангай суманд төрийн албан хаагчдын 8 айлын орон сууцанд засвар хийж, төрийн албан хаагчдыг орон байраар хангаж байна.

Сумдын 2024 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд хяналт хийж сумын ИТХ-р батлагдсан арга хэмжээг цахим систем (egazar.gov.mn)-д баталгаажуулан иргэд харах боломжийг бүрдүүлсэн. Үүнээс эрх зүйн харилцаа үүсгэхээр 1953 нэгж талбарын 2178.17 га газар олгохоор төлөвлөгдсөнөөс 1391 нэгж талбарын 1740.91 га газрыг иргэн, хуулийн этгээдэд эзэмшүүлж, өмчлүүлсэн. Хөдөө аж ахуйн 65 арга хэмжээний хүрээнд 26069.50 га газрыг хамгаалах, сайжруулах, ашиглуулах, нөхөн сэргээх, мод бут, сөөг тарихаар төлөвлөгдсөнөөс 14406.33 га бэлчээрийн талбайд хортон мэрэгчийн устгал хийж, 3990.07 га бэлчээрийн газрыг сэлгэн ашиглаж, 1768.90 га бэлчээрийн газрыг өнжөөн амрааж, уул уурхайн ашиглалтын улмаас эвдэрсэн 18.38 га газрыг нөхөн сэргээж, 2762.42 га



хадлангийн талбайг ашиглуулж, 3 булаг шандын эхийг хашиж, 6 худаг шинээр гаргаж, 302 га газарт шинээр мод, бут, сөөг тарьсан. Нийтийн эдэлбэр газарт шугам сүлжээ, холбоо мэдээлэл дамжуулах станцыг хууль, тогтоомжийн дагуу 128.6 га газарт хамгаалалтын бүсийг тогтоон мэдээллийн санд орууллаа. 2024 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт 71.2 хувьтай байна.

2024 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 146 нэгж талбарыг газар эзэмших эрхийн дуудлага худалдаагаар олгохоор төлөвлөгдсөний дагуу 131 нэгж талбарыг 1059.5 сая төгрөгөөр олгосон.

Тэшиг суманд улсын төсвийн 3.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар хоногт 6.0 тн сүү боловсруулах хүчин чадалтай сүүний үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажил 85 хувийн гүйцэтгэлтэй үргэлжилж, 2025 оны төсөвт 700.0 сая төгрөгийн санхүүжилт авахаар тусгагдаж, тоног төхөөрөмж, худалдан авч суурилуулах ажил үргэлжилж байна. (Зураг 1)

Зураг 1. Үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлын явц



Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд нийлүүлэгдсэн 263.2 сая төгрөгийн өртөг бүхий 7 сүүний хөргүүртэй танкыг "Хатан мээж хайрхан" ХХК-д түрээсээр эзэмшүүлж, сүү цуглуулахад дэмжлэг үзүүлэв. "АПУ Дэйринг" ХХК нь Баяннуур суманд сүүний хөргүүртэй танк байршуулж, хөргөлтийн цэгээр дамжуулан Улаанбаатар хот руу сүү татаж байна.

Засгийн газрын 2020 оны 130 дугаар тогтоолын дагуу 2023-2025 онд сүүний урамшуулалд "Хатан мээж хайрхан" ХХК шалгарч, нийт 798 нийлүүлэгчээс 641.4 тн сүү цуглуулж, 581468 л сүүг урамшуулалд хамруулж, аймгийн хэмжээнд 423,04 тн сүү сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн байна. (Зураг 2)

Зураг 2. Үйлдвэрлэсэн сүү сүүн бүтээгдэхүүн



УИХ-ын 2022 оны “Хүнсний хангамж, аюулгүй байдлын талаар авах зарим арга хэмжээний тухай” 36 дугаар тогтоолын хүрээнд 2 үйлдвэр хөрөнгө оруулалтын 230.0 сая төгрөг, 1 аж ахуйн нэгж эргэлтийн хөрөнгийн 150.0 сая төгрөгийн санхүүжилт авч “Дэлгэрэх” нарийн боовны цех хагас автомат үйлдвэрийн тоног төхөөрөмж суурилуулж, хүчин чадлыг 2 дахин нэмэгдүүлж, сав баглаа боодлыг сайжрууллаа.



1.3 Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт

Аймгийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөөг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XVIII хуралдааны XVIII/01 дүгээр тогтоолоор салбарын үр дүнг илэрхийлэх 11 зорилтын хүрээнд 213 арга хэмжээг төлөвлөн төлөвлөгөөний хэрэгжилт 2024 оны жилийн эцсийн байдлаар 88.07 хувь буюу “тодорхой үр дүнд хүрсэн” байна. Үүнээс үр дүнд хүрсэн 175 арга хэмжээ, тодорхой үр дүнд хүрсэн 20 арга хэмжээ, эрчимжүүлэх шаардлагатай 18 арга хэмжээ байна. Хэрэгжилт нь удаашралтай арга хэмжээнүүдээс 15 нь төсөв хөрөнгөгүй, 2 арга хэмжээ нь удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ аваагүй, 1 арга хэмжээ алдаатай төлөвлөлт зэргээс хамаарсан байна.

Аймгийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг аймгийн цахим хуудас (<https://bulgan.gov.mn/web/show/250100024>)-д байршуулан иргэд, олон нийтэд хүргэж байна.

Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний үр дүнг тоймлон хүргэж байна.

“Сургуульд суурилсан менежментийн загвар”-ыг үе шаттай хэрэгжүүлж удирдлагын манлайлал, менежмент 2.3 хувь, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт 4.0 хувь, хүүхдийн хөгжил хамгаалал 10.3 хувь ахисан амжилттай байна.

Аймгийн хэмжээст онооны дундаж 509 буюу өмнөх жилээс 4 пунктээр өссөн бол багшийн болон байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ 51.6 хувь буюу өмнөх оноос 4.5 хувиар өслөө.

Сургуулийн өмнөх насны 4524 хүүхдийн 3813 буюу 84.2 хувийг цэцэрлэгийн үйлчилгээнд хамруулсан нь өмнөх онтой харьцуулахад 1.3 пунктээр өсөж, 5 настай хүүхдийн цэцэрлэгт хамрагдалт 87.5 хувьд хүрсэн байна.

"Бэрхшээлийг биш боломжийг харъя" аянд 814 хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хамруулан, "Тусламжийн хонх"-ны үйлчилгээг 15 байгууллагад нэвтрүүлэн 76 дохионы хэлний цагаан толгой, 402 брайл үсгийн хаягжуулалт хийж, эрүүл мэндийн 50 төрийн албан хаагчдад дохионы хэлний анхан шатны чадвар эзэмшүүлэх сургалт зохион байгууллаа.

"Гэр бүлдээ цаг гаргая", "Харилцан хүндэтгэе", "Шалтаг бүү тооч" нөлөөллийн аяныг зохион байгуулж, аймгийн нийт өрхийн 68 хувийг хамруулснаар гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй гэмт хэргийн гаралт 8.3 хувиар буурсан байна.

"Теле камерын хяналтын дэд төв"-ийг байгуулан гэмт хэргийн илрүүлэлт өнгөрсөн оны мөн үеэс 15.1 хувиар өссөн дүнтэй байна.



Аймгийн хэмжээнд 50 айл өрх, 5 аж ахуйн нэгж хөрс бохирдуулагч нүхэн жорлонг буулгаж, 28 айл өрх, 10 аж ахуйн нэгж MNS 5924:2015 стандартын шаардлага хангасан эко жорлонтой боллоо.

Мал амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 1291.2 мянган мал, амьтан дархлаажуулалтад хамруулж, дархлаажуулалтыг 96.7 хувийн гүйцэтгэлтэй хийж гүйцэтгэснээр өвчний гаралт өмнөх оноос 0.2 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй "1 жуулчинд - 1 хонь" төсөл хөтөлбөрийн хүрээнд БНСУ-ын 6 жуулчин, БНСУ-ын "Thestar N CO" энтертайнментын 15 инфлүүнсэр, NAS DAILY студийн Япон, БНХАУ-ын Хонг Конг, БНСУ-ын 9 инфлүүнсэр, нийт 30 аялагч, жуулчид аймгийн нүүдэлчин ахуй соёлтой танилцан өвлийн аялал жуулчлалыг дэлхий нийтэд сурталчлав.

Булган-Орхон-Хишиг-Өндөр-Гурванбулаг чиглэлийн 133.7 км хатуу хучилттай авто замын төгсгөл 67.8 км ажлын үргэлжлэл ажил улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж эхэллээ.

Орхон сумын төвийн 3 км урт 0.4 кВт цахилгаан дамжуулах агаарын шугамыг сип кабелиар солих засварын ажил дуусаж, айл өрхүүдийг холбосон.

Могод сумын цахилгаан хангамжийн шинэчлэлийн ажил дуусаж, 16 км урт 0.4 кВт-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, 300 метр урт 10 кВт-ын цахилгаан дамжуулах агаарын шугамыг төмөр бетонон тулгуур болгох ажил үргэлжилж байна.

2023-2024 оны хичээлийн жилд "Шинэ багш" хөтөлбөрийн хүрээнд багшийн хувь хүний хөгжлийн сургалтыг олон талт хэлбэрээр зохион байгуулж, 10 гаруй чиглэлийн 500 гаруй цахим болон танхим хосолсон сургалтад давхардсан тоогоор 15000 орчим багш, удирдах ажилтан, албан хаагчид, эцэг, эх, суралцагчийг хамруулав. "Сургуульд суурилсан менежментийн загвар"-ыг Боловсролын яам, Боловсролын ерөнхий газар, "Шинэ монгол төв"-тэй хамтран үе шаттай хэрэгжүүлж, аймгийн хэмжээнд 16 ерөнхий боловсролын сургууль, 1 цэцэрлэгийг хамруулан сургуулийн менежментийн 3-4 загварыг туршин хэрэгжүүлснээр удирдлагын манлайлал, менежмент 2.3 хувь, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт 4 хувь, хүүхдийн хөгжил хамгаалал 10.3 хувь ахисан амжилттай байна.

"Шинэ ирээдүй" хөтөлбөрийн хүрээнд лектор болон ментор багш нар, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж, 90 гаруй сургалт, нөлөөллийн арга хэмжээ, гүйцэтгэл оношлох үнэлгээ зэрэг томоохон ажлуудад давхардсан тоогоор 28249 хүүхдийг хамруулав. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтыг ерөнхий боловсролын 8-12 дугаар ангийн 1620 сурагч, "Мэргэжил сонголт-



Амжилтын үндэс" сургалт, өдөрлөгийг 2-9 дүгээр ангийн сурагч нарт 2-5 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 8800 гаруй хүүхэд, 750 гаруй эцэг эх, асран хамгаалагчийг хамруулсан байна. Сургуульд бэлтгэгдсэн байдал, анги дэвших, төгсөх болон улсын шалгалт, элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх ажлын хүрээнд 12-р ангийн 1800 гаруй сурагчийг хамруулан математикийн судлагдахуун 5.1 хувиар, англи хэлний судлагдахуун 4.4 хувиар суурь түвшнээс тус тус өсөж, сурлагын хоцрогдол нөхөх, арилгах цогц төлөвлөгөөний биелэлт 72.1 хувь буюу улсын дунджаас дээгүүр үнэлэгдлээ.

“Эрүүл чийрэг эр хүн”, “Харшлаас сэргийлэх”, “Элэг бүтэн Монгол”, “Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх”, “Хавдрын эсрэг” арга хэмжээнүүдийн төлөвлөгөөг 80 хувьтай хэрэгжүүллээ.

2024 онд аймгийн эрүүл мэндийн салбарт “Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жил” болгон зарлаж, эрүүл мэндийн боловсрол олгох 261 удаагийн сургалт сурталчилгааг төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн дунд зохион байгуулан, давхардсан тоогоор 40624 иргэнийг хамруулсан.

Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, иргэдийг идэвхтэй дасгал хөдөлгөөнөөр хичээллэх идэвхийг нэмэгдүүлэх зорилгоор “Сансар марафон-2024” бүх нийтийн гүйлтийн арга хэмжээг 4 дэх жилдээ 8 насны ангиллаар зохион байгуулж, Улаанбаатар хот, Орхон аймгийн 100 гаруй тамирчид болон 400 гаруй иргэд, хүүхэд, залуучууд хурд хүч авхаалж самбаагаа сорин өрсөлдлөө. (Зураг 3)

Зураг 3. “Сансар марафон 2024” бүх нийтийн гүйлтийн тэмцээн



“Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт хэлэлцээр”-ийг 14 сумтай байгуулан, 91.0 хувьтай хэрэгжүүллээ.

Аймгийн хэмжээнд төр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар түр ажлын байр 411, улирлын ажлын байр 82, байнгын ажлын 411, нийт 904 шинэ ажлын байр бий болсныг хөдөлмөр эрхлэлтийн программд бүртгэн, аж ахуйн нэгж, иргэдээс ирсэн сул чөлөөтэй ажлын байранд 1165 иргэнийг зуучлан, хөдөлмөр эрхлэлтийг дэмжин ажилласан.

Орон нутгийн төсвийн 25.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар ахмадын амралтад 7 нэр төрлийн 16 ширхэг тоног төхөөрөмжийн хангалтыг хийж, үйлчилгээнд шаардагдах тоног төхөөрөмжийн хангалтыг 100 хувьд хүргэн, Нийгмийн даатгалын газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн хурлын өрөөг 15.0 сая төгрөгөөр тохижуулсан. (Зураг 4)

Зураг 4. Ахмадын амралтын тоног төхөөрөмж



Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд 54 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлснээс 10.3 тэрбум төгрөгийн 37 ажилд комисс ажиллаж, байнгын ашиглалтад оруулаад байна. (Зураг 5)

Зураг 5. АЗДТГ-ын барилгын фасад солих ажил





1.4. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5 бүлэг, 103 зорилтын хэрэгжилтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ. (Хүснэгт 3)


Хүснэгт 3. Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт

	Нийт	Хүний хөгжлийн бодлого	Эдийн засгийн бодлого	Ногоон хөгжлийн бодлого	Засаглалын бодлого	Бүс, орон нутгийн хөгжлийн бодлого
Зорилтын тоо	103	29	22	22	20	10
“Үр дүнтэй” /100 хувь/	45	15	9	9	9	3
“Тодорхой үр дүнд хүрсэн” /70-100 хүртэл хувь/	52	14	10	11	10	7
“Эрчимжүүлэх шаардлагатай” /30-70 хүртэл хувь/	6	0	3	2	1	0
“Үр дүнгүй” /0-30 хүртэл хувь/	0	0	0	0	0	0
Хувь	91.9	95.3	92.3	91.0	92.4	88.5

Хөтөлбөрийн хэрэгжилтэд 2024 оны байдлаар өссөн дүнгээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 91.9 хувь буюу “тодорхой үр дүнд хүрсэн” байна.

Хүний хөгжлийн бодлогын 29 зорилт 95.3 хувь, эдийн засгийн бодлогын 22 зорилт 92.3 хувь, ногоон хөгжлийн бодлогын 22 зорилт 91.0 хувь, засаглалын бодлогын 20 зорилт 92.4 хувь, бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын 10 зорилт 88.5 хувьтай хэрэгжсэн байна. (График 3)


График 3.Хөтөлбөрийн хэрэгжилт (бодлого тус бүрээр)





Үүнд 45 зорилт 100 хувь буюу үр дүнтэй, 52 зорилт 70.0-100 хүртэл хувь буюу тодорхой үр дүнд хүрсэн, 6 зорилт 30.0-70.0 хүртэл хувь буюу эрчимжүүлэх шаардлагатай байна. (График 4)


График 4. Зорилтын хэрэгжилт (үнэлгээний ангиллаар)



Тус хөтөлбөрийн 2 зорилтын хэрэгжилт 30.0 хувь, 1 зорилтын хэрэгжилт 50.0 хувийн хэрэгжилттэй байгаа ба энэхүү зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийн хүрээнд бэлтгэл ажил хийгдсэн, дээд шатны байгууллагад хүсэлтээ уламжилсан боловч хөрөнгийн асуудал шийдвэрлэгдээгүй, холбогдох байгууллагын шийдвэр гараагүй зэргээс шалтгаалан хэрэгжилт нь удааширчээ.

Дээрх 103 зорилтыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 259 арга хэмжээнээс 168 арга хэмжээ 100 хувь, 52 арга хэмжээ 90.0 хувь, 22 арга хэмжээ 70.0 хувь, 6 арга хэмжээ 50.0 хувь, 10 арга хэмжээ 30.0 хувь, 1 арга хэмжээ 0 хувийн хэрэгжилттэй байна. (График 5)

График 5. Арга хэмжээний үнэлгээ (үнэлгээний ангиллаар)



Аймгийн Засаг даргын 2020-2024 оны “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг тооцож, үнэлэхэд 2021-2024 онд санхүүжилт нь шийдвэрлэгдсэн зорилт, арга хэмжээнүүд төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн ба нийт зорилтын 94.2 хувь, арга хэмжээний 93.4 хувь нь үр дүнтэй болон тодорхой үр дүнд хүрсэн байна. Харин



зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэр нь тодорхойгүй болон төсөвт тусгагдаагүйгээс шалгаалж зарим ажлууд удааширсан байна. Тухайлбал 15 нь төсөв хөрөнгөгүй, 2 арга хэмжээ нь удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ аваагүй, бусад байгууллагын шийдвэр гараагүй зэргээс хамаарчээ.


Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2024 оны хэрэгжилтийн үр дүнг тоймлон хүргэж байна.

ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Эрүүл мэнд

Эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, стандартыг хангах зорилгоор 2024 онд 7.5 тэрбум төгрөгийн ажил, арга хэмжээг төлөвлөн ажилласан. Төлөвлөгөөний дагуу Дашинчилэн сумын Эрүүл мэндийн төвийн барилгын цэвэр, бохир усны шугам, дэд бүтцийн ажил, Бугат, Хутаг-Өндөр сумын Эрүүл мэндийн төвийн засварын ажлууд бүрэн хийгдэж дуусаад байна. (Зураг 6)

Зураг 6. Бугат, Хутаг-Өндөр сумын эрүүл мэндийн төвийн засвар



Эмнэлгийн нэн шаардлагатай тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлэхэд 2024 онд улсын төсвийн 700.0 сая, орон нутгийн төсвийн 319.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдлээ. Тухайлбал: аймгийн Нэгдсэн эмнэлэгт урологийн мэс заслын тоног төхөөрөмж, чих, хамар хоолойн багаж, ариутгалын автоклаб, анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудад оношилгоо, эмчилгээний 9 нэр төрлийн тоног төхөөрөмжөөр хангаснаар аймгийн хэмжээнд эрүүл мэндийн байгууллагуудын тоног төхөөрөмжийн стандартын хангалт өмнөх оноос 2.5 пунктээр нэмэгдэж, 92.4 хувьд хүрсэн байна. (Зураг 7)


Зураг 7. Нэгдсэн эмнэлэгт нийлүүлэгдсэн тоног, төхөөрөмж



2024 онд орон нутгийн төсвийн 216.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар сумын Эрүүл мэндийн төвүүдийг оношилгоо, эмчилгээ, нүүр амны тусламж үйлчилгээний 9 нэр төрлийн тоног төхөөрөмжөөр хангаж яаралтай тусламжийн чанар, хүртээмжийг сайжрууллаа.

"Хүрч үйлчилье" нэгдсэн арга хэмжээний хүрээнд аймгийн Засаг даргын нэрэмжит нарийн мэргэжлийн эмчийн үзлэгийг Баян-Агт Сайхан, Тэшиг, Хангал, Хутаг-Өндөр, Хишиг-Өндөр, Могод сум, Хялганат тосгонд зохион байгуулж, давхардсан тоогоор 3101 иргэнийг эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд хамруулсан. Эрт илрүүлэг үзлэг, оношилгоогоор дотоод шүүрэл тэжээлийн ба бодисын солилцооны өвчин, шээс бэлгийн тогтолцооны өвчин, зүрх судасны тогтолцооны өвчин, амьсгалын тогтолцооны өвчлөлүүд бүртгэгдэж, өвчлөлийн тэргүүлэх шалтгаан болж байна. Онош тодруулах, эмчлүүлэх шаардлагатай 36 хүнийг дараагийн шатны эмнэлэгт шилжүүлэв. (Зураг 8)

Зураг 8. Нарийн мэргэжлийн үзлэг, оношилгоо



Эрүүл шүд-Эрүүл хүүхэд" аяны хүрээнд 0-17 насны 16872 хүүхэд буюу нийт хамрагдвал зохих хүүхдийн 77.2 хувийг үзлэгт хамруулж, өвчлөл илэрсэн

хүүхдүүдийн 85.0 хувийг эмчилгээнд хамруулан, 40 хувийг нь бүрэн эмчилсэн байна.
(Зураг 9)

Зураг 9. Хүүхдийн шүдний үзлэг



Аймгийн хэмжээнд 202 сувилагч, 83 эмнэлгийн тусгай мэргэжилтэн ажиллаж байгаа бөгөөд салбарын хүний нөөцийн хангалт 88.5 хувьд хүрч, өмнөх оноос 0.5 пунктээр өссөн.

Төгсөлтийн дараах үндсэн мэргэжил олгох сургалтад 4 их эмч, төрөлжсөн мэргэшил олгох сургалтад 3 их эмч, 4 сувилагч, мэргэжил дээшлүүлэх сургалтад 5 эмнэлгийн тусгай мэргэжилтэн хамрагдсан. Аймгийн хэмжээнд давхардсан тоогоор 1400 эмнэлгийн мэргэжилтэн ажлын байрны давтан мэргэшүүлэх сургалтад, 15 мэргэжилтэн гадаад сургалтад хамрагдаж байна.

Орон нутагт ажиллаж байгаа эмч, эмнэлгийн мэргэжилтний нийгмийн баталгааг хангах үүднээс Бүрэгхангай, Тэшиг сум 1 их эмч, 1 сувилагчид амьдрах байр, байшин шинээр барьж өгч, Хутаг-Өндөр, Сайхан сум, Хялганат тосгонд баригдсан төрийн албан хаагчийн орон сууцанд 4 их эмч, 1 сувилагч амьдарч байна. Бугат, Бүрэгхангай, Гурванбулаг, Орхон сумын эрүүл мэндийн төв болон аймгийн Нэгдсэн эмнэлгийн Халдварт сүрьеэгийн тасгийн хуучин барилгад 15 ажилтныг амьдрах байраар хангасан.

Эрүүл мэндийн байгууллагуудын 95.0 хувь нь нүхэн нойлыг үе шаттайгаар орчин үеийн ариун цэврийн байгууламжаар сольж, стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай болсон.

Боловсрол

2023-2024 оны хичээлийн жилд "Шинэ багш" хөтөлбөрийн хүрээнд багшийн хувь хүний хөгжлийн сургалтыг олон талт хэлбэрээр зохион байгуулж, 10 гаруй чиглэлийн 500 гаруй цахим болон танхим хосолсон сургалтад давхардсан тоогоор



15000 орчим багш, удирдах ажилтан, албан хаагчид, эцэг эх, суралцагчийг хамруулав. “Сургуульд суурилсан менежментийн загвар”-ыг Боловсролын яам, Боловсролын ерөнхий газар, “Шинэ Монгол төв”-тэй хамтран үе шаттай хэрэгжүүлж аймгийн хэмжээнд 16 ерөнхий боловсролын сургууль, 1 цэцэрлэгийг хамруулан сургуулийн менежментийн 3-4 загварыг туршин хэрэгжүүлснээр удирдлагын манлайлал, менежмент 2.3 хувь, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт 4 хувь, хүүхдийн хөгжил хамгаалал 10.3 хувь ахисан амжилттай байна. (Зураг 10)

Зураг 10. Багш нарыг чадавхижуулах сургалт



Багш ажилчдыг урамшуулах, нийгмийн баталгааг хангах, ажиллах орчин нөхцөлийг сайжруулахад орон нутгийн төсвөөс 10.5 сая төгрөг зарцуулан, Хутаг-Өндөр, Тэшиг, Хангал, Сайхан сум, Хялганат тосгонд 14 айлын орон сууц ашиглалтад орсон.

"Шинэ ирээдүй" хөтөлбөрийн хүрээнд лектор болон ментор багш нар, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж, 90 гаруй сургалт, нөлөөллийн арга хэмжээ, гүйцэтгэл оношлох үнэлгээ зэрэг томоохон ажлуудад давхардсан тоогоор 28249 хүүхдийг хамруулав. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтыг ерөнхий боловсролын 8-12 дугаар ангийн 1620 сурагч, "Мэргэжил сонголт-Амжилтын үндэс" сургалт, өдөрлөгийг 2-9 дүгээр ангийн сурагч нарт 2-5 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 8800 гаруй хүүхэд, 750 гаруй эцэг эх, асран хамгаалагчийг хамруулсан байна. Сургуульд бэлтгэгдсэн байдал, анги дэвших, төгсөх болон улсын шалгалт, элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх ажлын хүрээнд 12-р ангийн 1800 гаруй сурагчийг хамруулан математикийн судлагдахуун 5.1 хувиар, англи хэлний судлагдахуун 4.4 хувиар суурь түвшнээс тус тус өсөж, сурлагын хоцрогдол нөхөх, арилгах цогц төлөвлөгөөний биелэлт 72.1 хувь буюу улсын дунджаас дээгүүр үнэлэгдлээ.

Ерөнхий боловсролын II-V ангийн сурагчдын дунд “Математик”, “Монгол хэл-Унших бичиг”-ийн масс олимпиадыг 2 үе шаттайгаар зохион байгуулж, математикийн төрөлд давхардсан тоогоор 278 анги бүлгийн 7276 суралцагч, “Монгол хэл-Унших бичиг”-ийн төрөлд давхардсан тоогоор 278 анги бүлгийн 17264 суралцагч хамрагдсан. Англи хэлний масс олимпиадын I даваанд 30 гаруй бүлгийн 700 суралцагч, II даваанд 10 гаруй бүлгийн 300 гаруй суралцагч хамрагдсан байна. Математикийн хичээлийн олимпиадыг нэрт математикч Д.Шагдарын нэрэмжит болгон 6 ангилал, 9 төрлөөр 353 оролцогчийг хамруулан зохион байгуулж, 1-3 дугаар байрт шалгарсан 103 багш, суралцагчийг урамшууллаа. Монгол хэлний улсын анги нийтийн олимпиадад 2 дугаар сургуулийн 9 дүгээр анги дэд байрт шалгарсан амжилтыг үзүүлсэн. (Зураг 11)

Зураг 11. Улсын төрөлжсөн олимпиадын шагналт байр



Сургууль, багш бүр элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх төлөвлөгөө гарган, 12 дугаар ангийн сурагчдаас ахиц амжилтын судалгааг сар бүр авч зөвлөмж, чиглэл хүргүүлэн ажиллаж байна. Мөн Сорил-2024 урьдчилсан элсэлтийн шалгалтыг Боловсролын үнэлгээний төвтэй хамтран бүсчилсэн хэлбэрээр Дашинчилэн, Хутаг-Өндөр, Булган сумын 1 дүгээр сургуульд зохион байгуулж, 10 судлагдахууны хүрээнд элсэлтийн шалгалт өгөхөөр бүртгүүлсэн нийт сурагчдын 90 хувийг хамруулсан. Элсэлтийн ерөнхий шалгалтаар өндөр оноо авсан 26 суралцагчид 150.1 сая төгрөгийн сургалтын төлбөрийн тэтгэлэг олгоод байна.

Аймгийн Засаг даргын нэрэмжит тэтгэлэгт хөтөлбөрийг 4 дэх жилдээ хэрэгжүүлэн 344 суралцагчид 1443.3 сая төгрөгийн сургалтын төлбөрийн тэтгэлэг, дэмжлэг, урамшуулал олгов. (Зураг 12)

Зураг 12. Засаг даргын нэрэмжит тэтгэлэг



2024 онд боловсролын салбарт улсын төсвөөс 10.9 тэрбум, орон нутгийн төсвөөс 3.7 сая төгрөг, нийт 11.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтууд хийгдлээ.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Булган сумын 280 хүүхдийн цэцэрлэгийн барилга, Дашинчилэн сумын 150 хүүхдийн дотуур байр, Хутаг-Өндөр сумын 120 хүүхдийн цэцэрлэг, сургууль цэцэрлэгийн нүхэн жорлонг ариун цэврийн байгууламжаар солих 3 дугаар шатны ажил Дашинчилэн, Хишиг-Өндөр, Орхон, Сайхан, Баян-Агт, Бугат суманд хэрэгжсэн. (Зураг 13, 14)

Зураг 13. Дашинчилэн сумын 150 ортой дотуур байрны барилга



Зураг 14. Булган, Хутаг-Өндөр сумын цэцэрлэгийн барилга



Боловсролын салбарт шаардлагатай тоног төхөөрөмж, техник, хэрэгслээр хангах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэн улсын төсвөөс 700.0 сая төгрөгийн санхүүжилтээр 587 ширхэг зөөврийн компьютер, 184 ширхэг ухаалаг дэлгэцийг нийлүүлэв. (Зураг 15)

Зураг 15. Боловсролын салбарт нийлүүлэгдсэн техник хэрэгсэл



Улсын төсвийн 82.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Баян-Агт, Могод, Сайхан, Хутаг-Өндөр суманд 12 ширхэг иж бүрэн гэр цэцэрлэгийг нийлүүлж, 4 сургуулийн англи хэлний лингафон танхимыг 319.8 сая төгрөгөөр тохижуулав. (Зураг 16)

Зураг 16. Сумдад олгогдсон гэр цэцэрлэг



Хутаг-Өндөр сумын 120 хүүхдийн цэцэрлэгийн барилгын ажлыг "Алтайн бумбат өргөө" ХХК улсын төсвийн 1703.6 сая төгрөгөөр барьж, 2024 оны 12 дугаар сард улсын комисс хүлээн авч, ашиглалтад оруулсан. (Зураг 17)

Зураг 17. Хутаг-Өндөр сумын цэцэрлэгийн барилга



Биеийн тамир, спорт

Биеийн тамир, спортыг аймаг орон нутагтаа хөгжүүлэх, өсвөр залуу үеийг спортоор хичээллэх нөхцөл боломжийг бүрдүүлж, улс, бүсийн чанартай тэмцээн уралдаанд оролцсон тамирчдын амжилтыг нэмэгдүүлэх зорилгоор 2024 онд аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 12 спортын холбоотой хамтран ажиллах гэрээ байгуулан, улс бүсийн болон аймгийн чанартай 34 төрлийн уралдаан тэмцээнүүдийг амжилттай зохион байгуулж, 25000 орчим иргэдийг хамруулан орон нутгийн төсвөөс 200.0 сая төгрөг зарцууллаа.

Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх чиглэлээр аймгийн хэмжээнд 63 багш дасгалжуулагчийн удирдлага дор 23 төрлийн секц, дугуйланд 3124 хүүхэд тогтмол хичээллэж байгаа бөгөөд “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний хүрээнд “Эрүүл нийгэм”, Цаг гаргая” аяныг зохион байгуулж, 30 орчим арга хэмжээнд 27000 гаруй иргэд хамрагдаад байна. (Зураг 18)

Зураг 18. “Эрүүл нийгэм”, “Цаг гаргая” 2024 аян



Монгол Улсын гавьяат дасгалжуулагч Г.Баатар агсны нэрэмжит өсвөрийн цанын улсын аварга шалгаруулах тэмцээнд 15 багийн 126 тамирчин, самбо бөхийн олон улсын хэмжээний мастер, дасгалжуулагч Н.Мөнхөө агсны нэрэмжит самбо бөхийн өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээнд 32 багийн 420 гаруй тамирчид өрсөлдсөн. (Зураг 19)

Зураг 19. Спортын тэмцээн уралдаан



Өсвөрийн шигшээ багийг бэлтгэх хөтөлбөрийн хүрээнд шигшээ багийг 12 төрлөөр байгуулж, бэлтгэл сургуулилт, хэрэглэл материал, тэмцээний зардалд орон нутгийн төсвөөс 90.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Улс, бүс, олон улс, аймаг орон нутгийн чанартай 54 удаагийн тэмцээн уралдаанд өсвөрийн 2478 тамирчин оролцож, 332 медаль хүртэж, үзүүлсэн амжилт өмнөх оны мөн үеэс 14 хувиар өссөн үзүүлэлтэй байна. (Зураг 20)

Зураг 20. Өсвөрийн шигшээ багийн тамирчид.
ӨСВӨРИЙН УАШТ 2024



Үндэсний спортыг хөгжүүлэх зорилгоор Булган аймгийн харьяат “Таван аваргын нэрэмжит 128 бөхийн барилдаан”, “Мөнгөн өвөл-2024” арга хэмжээг Булган суманд зохион байгуулж мөсний сур, шагайн төрөлд 4 аймгийн 6 багийн 202 тамирчид, “Харгалын хүчтэний цом” үндэсний бөхийн өсвөр үе, залуучуудын нээлттэй тэмцээнд 12 байгууллагын 176 тамирчин тус тус амжилттай оролцлоо. Мөн үндэсний шагайн харвааг хөгжүүлэх хүрээнд “Хангинахын шугуйн шагайн

тойром” арга хэмжээнд 30 багийн 350 гаруй тамирчин, Улаанбаатар хотод зохион байгуулагдсан ахмадын шагайн харвааны улсын аварга шалгаруулах тэмцээнд 2 багийн 30 тамирчин амжилттай оролцов. Дээрх арга хэмжээнүүдийн үр дүнд аймгийн спортын холбоодын үйл ажиллагаа тогтмолжиж, хичээллэгсдийн тоо суурь түвшинтэй харьцуулахад 3 дахин нэмэгдсэн байна. (Зураг 21)

Зураг 21. Үндэсний спортын тэмцээн уралдаан.



Гадаад орнуудтай хамтын ажиллагааг сайжруулах, тамирчдын ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор дэмжлэг үзүүлж, Тайланд улсад зохион байгуулагдсан насанд хүрэгчдийн модон барилдааны дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд 1 алт, Хөнгөн атлетикийн ази тивийн аварга шалгаруулах тэмцээнд 1 мөнгө, "Парис-2024" паралимпын наадмын хөнгөн атлетикийн бөөрөнцөг түлхэлтийн /F40 ангилал/ төрөлд оролцсон ОУХМ Ц.Баттулга мөнгөн медаль хүртсэн амжилт үзүүллээ. (Зураг 22)

Зураг 22. Медальт байрт шалгарсан тамирчдын төлөөлөл.



Соёл, урлаг

Иргэд олон нийтийг соён гэгээрүүлэх, бүх нийтэд соёлын боловсрол олгох, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, өв соёлыг түгээн дэлгэрүүлэх ажлын хүрээнд 169 уралдаан тэмцээн, 282 тоглолт, 30388 үзвэр үйлчилгээ, бусад арга хэмжээг зохион байгуулж, давхардсан тоогоор 281008 хүнд соёлын үйлчилгээг хүргэлээ. Зохион байгуулсан үйл ажиллагааны тоо суурь түвшинтэй харьцуулахад 0.5 хувиар, үйл ажиллагаанд оролцогчдын тоо 0.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Соёл Урлагийн Их сургуультай хамтран ажиллах гэрээ байгуулж, элсэлтийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, 12 хүүхдэд аймгийн Засаг даргын нэрэмжит тэтгэлэг олгосон.

Аймгийн соёл урлагийн салбарт ажиллаж буй мэргэжлийн бус албан хаагчдад эчнээгээр сурахад дэмжлэг үзүүлж, 2024 оны жилийн эцсийн байдлаар мэргэжлийн хүний нөөцийн хангалт 68.2 хувь болж, өмнөх оноос 2.7 пунктээр нэмэгдсэн байна.

Ардын урлаг, соёл, уламжлалыг түгээн дэлгэрүүлэх, өвлүүлэн уламжлуулах ажлын хүрээнд "Булган хангай 2024" хойд бүсийн хүүхдийн урлагийн их наадмыг амжилттай зохион байгууллаа. (Зураг 23)

Зураг 23. "Булган хангай" хойд бүсийн хүүхдийн урлагийн их наадам



Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тусгагдсан хүмүүнлэг, оюунлаг, ёс суртахуунтай, үндэсний соёлын мэдлэгтэй, бүтээлч иргэнийг төлөвшүүлэх зорилгоор 11 дүгээр сарыг соёлын бүтээлч сар болгон зарлаж, аяны хүрээнд 133 арга хэмжээг зохион байгуулан ажиллалаа. Тухайлбал: Сайхан бичигтэн, хурдан уншигч, уран бичлэг, монгол бичгийн гайхамшиг, "Төр, нийгмийн зүтгэлтэн С.Удвал" бяцхан ном бүтээх, "Буриад өв соёл" ханын сонин бүтээх зэрэг уралдаануудад 5553 хүүхэд, залуучуудыг хамрууллаа. (Зураг 24)

Зураг 24. “Соёлын бүтээлч сар 2024”



“Алтаргана 2024” олон улсын XV их наадмыг 07 дугаар сарын 26-28-ны өдрүүдэд зохион байгуулж, нээлт, баярын жагсаал, хаалтын арга хэмжээнд 200 гаруй уран бүтээлчид оролцож, соёл, спорт, хэвлэл мэдээллийн чиглэлээр зохион байгуулагдсан 22 төрлийн тэмцээн уралдаанд гадаад, дотоодын 1700 гаруй иргэд авьяас, мэдлэг, ур чадвараа сорин өрсөлдлөө. Мөн наадмын 22 төрлийн тэмцээн уралдаан болон соёлын цогц арга хэмжээг 60 мянга орчим иргэд, жуулчид үзэж сонирхлоо. (Зураг 25)

Зураг 25. “Алтаргана 2024” олон улсын XV их наадам



Монгол Улсын Засгийн газраас 2023-2025 оныг “Монголд зочлох жил” болгон зарласантай холбогдуулан Монгол Улсыг гадаадад сурталчлан таниулах, аялал жуулчлалын салбарын үйл ажиллагааг сэргээх, эдийн засгийг сайжруулах, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зорилгоор “Айраг фестиваль 2024” арга хэмжээг 2024 оны 08 дугаар сарын 16-18-ны өдрүүдэд зохион байгуулж, ардын уламжлалт ёс, зан үйлийг сэргээх, түүнийг дагасан уламжлалт 12 тэмцээн уралдааныг зохион байгуулан 547 тамирчин оролцож, нээлт, хаалт, гэр тоглолтыг 17500 гаруй жуулчид үзэж сонирхсон байна. (Зураг 26)

Зураг 26. “Айраг Фестиваль-2024”



Соёлын биет бус өвийг хадгалж хамгаалах, түүнийг өвлөн уламжлагчийг тодруулах, алдаршуулах, авьяас билгийг хөгжүүлэх, олон нийтэд сурталчлан, түгээн дэлгэрүүлэх зорилгоор “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивальд соёл урлагийн салбарын уран бүтээлчид болон соёлын бүтээлч үйлдвэр эрхлэгчдийн хамтарсан 45 хүний бүрэлдэхүүнтэй оролцож, уламжлалт гар урлалын 5 ай савд багтах модны ур, модон сийлбэрийн урлал, арьс ширэн урлал, эсгий ширмэл урлал, даавуун зүймэл урлалын бүтээлүүд багтсан 26 өвийн төрлийг дэлгэрүүлж, үзүүлбэр тоглолт, үзэсгэлэнгээр дамжуулан олон нийтэд сурталчлан таниуллаа. (Зураг 27)

Зураг 27. “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестиваль наадам



Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт хамгаалалтыг сайжруулах зорилгоор улс, аймгийн хамгаалалттай 53 дурсгалаас 2024 оны жилийн эцсийн байдлаар 41 дурсгалыг хашаажуулан хамгаалах гэрээг байгуулсан.

Улсын төсвийн 2.9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Нийтийн номын сангийн шинэ барилга ашиглалтад орж, иргэдэд номын сангийн үйлчилгээг чанартай, жигд хүртээмжтэй хүргэх нөхцөл боломжийг бүрдүүллээ. (Зураг 28)




Зураг 28. Нийтийн номын сан



Орхон сумын соёлын төвийн их засвар, Аймгийн Музейн их засвар, Хангал сумын соёлын төвийн тайз, орон нутаг судлах танхимын засвар, Тэшиг сумын соёлын төвийн ариун цэврийн байгууламжийн засварыг орон нутгийн төсвийн 1.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 100 хувь хийж гүйцэтгэлээ. (Зураг 29)

Зураг 29. Соёл, урлагийн салбарын хөрөнгө оруулалт



Аймгийн соёлын байгууллагуудын тоног төхөөрөмжийг сайжруулах зорилгоор орон нутгийн төсвийн 763.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Булган сумын соёлын ордонд автомашин, 6 сумын соёлын төвд лед дэлгэц, Булган, Тэшиг, Сэлэнгэ, Хутаг-Өндөр, Гурванбулаг суманд 214.4 сая төгрөгөөр техник, тоног төхөөрөмж нийлүүлсэн. Мөн улсын төсвийн 153.0 сая төгрөгөөр 21 байгууллагад зөөврийн болон суурин компьютер, принтер олгож, театр, соёлын төвүүдийн техник тоног төхөөрөмжийн хангалт 90.0 хувьд хүрснээр иргэд олон нийтэд соёлын үйлчилгээг чанартай, саадгүй хүргэх нөхцөл боломж бүрдэж байна.


Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал

Нийгмийн хамгааллын болон иргэний хөдөлмөрлөх эрх, түүнтэй холбогдсон хөдөлмөрийн харилцааны нийтлэг асуудлаар “Аймгийн хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт 2023-2024 оны хэлэлцээр”-ийг байгуулж, хэлэлцээрийн

хүрээнд Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн улсын үзлэгийг өмчийн хэлбэр харгалзалгүй 88 байгууллагад зохион байгуулж, Хөдөлмөрийн тухай хуулийн үзлэгийн дүн 91.0, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн үзлэгийн дүн 82.8 хувьтай үнэлэгдсэн.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн малжуулах арга хэмжээнд зудад нэрвэгдсэн сум, өрхөөс түлхүү сонгон, 180 өрхийг 1.4 тэрбум төгрөгийн 8118 толгой малаар малжуулан, 360 иргэний ажлын байрыг хадгалж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжин ажиллалаа. Тус арга хэмжээний хүрээнд төсөлд хамрагдсан малчин өрхүүдэд малын асаргаа, бэлчээр ашиглалт, малчин иргэдийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлийн сургалтыг зохион байгуулж, 70 иргэнийг хамруулсан. (Зураг 30)

Зураг 30. ХЭДС-ийн малжуулах арга хэмжээ



Залуучуудын гарааны бизнесийг дэмжих арга хэмжээг “Старт ап маркетинг спейс” сургалтын төвтэй хамтран 11 дүгээр сард 15 багийн 32 залууг хамруулан зохион байгуулсан. Шинэ технологи, инновац бүхий шинэлэг санал, санаачилга гарган аж ахуй эрхлэх төсөл боловсруулсан залуучуудын бүлгийг нээлттэй өрсөлдөөний зарчмаар сонгон шалгаруулж, Хангал сумын “Sunrise” багийн катеринг үйлчилгээнд 10.0 сая төгрөгийн эргэн төлөхгүй нөхцөлтэй санхүүжилтийг олгосон. (Зураг 31)

Зураг 31. Залуучуудын гарааны бизнесийг дэмжих арга хэмжээ





Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, ажилгүйдлийн түвшнийг бууруулах зорилгоор ажил олгогч иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас давхардсан тоогоор 2293 сул чөлөөтэй ажлын байрны захиалга авч, 1165 иргэнийг хөдөлмөрт зуучилснаас байнгын ажлын байранд 587 иргэн зуучлагдан ажлын байртай болсон. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсөл, хөтөлбөрт 1735 иргэнийг хамруулан, 2.5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг зарцуулж, иргэдийн аж ахуй эрхлэлтийг дэмжсэнээр 2024 онд төсөл хөтөлбөрийн хүрээнд 904 шинэ ажлын байрыг бий болгож, 425 иргэний ажлын байрыг хадгалсан. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг хэрэгжүүлснээр ажилгүйдлийн түвшин 2024 оны 4 дүгээр улирлын байдлаар 1.5 хувь болсон нь өнгөрсөн оны мөн үеэс 5.7 пунктээр буурсан үзүүлэлттэй байна. (График 6)

График 6. Ажилгүйдлийн түвшин /сүүлийн 4 жилээр/




Амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой иргэдийг ажилтай болгон орлогыг нэмэгдүүлэх, өрхийн гишүүдийг хөгжүүлж, нийгмийн баталгааг хангах чиглэлээр “ЗӨВ ГЭР БҮЛ-20” арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллалаа. Тус арга хэмжээний хүрээнд “Хүүхэд хамгааллыг хамтдаа хөгжүүлье” арга хэмжээг 2 суманд, нийгмийн салбарын “Хүрч үйлчилье” нэгдсэн арга хэмжээг 16 суманд зохион байгуулж, эрүүл мэнд, нийгмийн халамж, нийгмийн даатгал, хүүхэд хамгааллын үйлчилгээг хөдөө орон нутгийн иргэдэд хүргэсэн.

Зорилтот өрхийн гишүүдээс давхардсан тоогоор 317 иргэнийг ажлын байртай болгон, мэргэжил олгох сургалтад 33, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн малжуулах болон санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд 39 иргэнийг хамруулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжин ажилласны үр дүнд хүнсний эрхийн бичгийн

үйлчилгээнд хамрагддаг, халамж хүртэгч иргэдийн тоо өмнөх оноос 403 иргэнээр буурсан байна. (График 7)

График 7. Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ /сүүлийн 4 жилээр/



Аймгийн хэмжээнд хүчирхийлэлд өртсөн хүүхэд, эмэгтэйчүүд, иргэдэд үйлчлэх нэг цэгийн үйлчилгээний төв болох түр хамгаалах байрыг Булган суманд 149.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар барьж, 2024 онд улсын комисс хүлээн авч үйл ажиллагааг эхлүүлсэн. Орон нутгийн 25.0 сая төгрөгийн санхүүжилтээр дотоод хяналтын камер суурилуулсан.

2024 онд улс, орон нутгийн төсөв, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын хөрөнгө оруулалтаар "Жаргалант" хүүхдийн зусланг ашиглалтад оруулан тоног төхөөрөмжөөр хангаж, хүүхэд хөгжлийн зуны хөтөлбөрийг хэрэгжүүлэн 2 ээлж бүхий Булган, Орхон, Хөвсгөл аймгийн 168 хүүхдийг хүлээн авч ажилласан. (Зураг 32)

Зураг 32. "Жаргалант" хүүхдийн зуслангийн үйл ажиллагаа






ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

Эдийн засгийн тогтвортой хөгжил

Аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүн 2023 оны жилийн эцсийн байдлаар 630.1 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 14.6 хувиар, нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн 10.3 сая төгрөгт хүрч, өмнөх оноос 16 хувиар тус тус өссөн байна. 2024 оны дотоодын нийт бүтээгдэхүүн 680.0 тэрбум төгрөгт хүрэх урьдчилсан тооцоо байна. (График 8)

График 8. Дотоодын нийт бүтээгдэхүүн



Булган аймгийн эдийн засгийн үндсэн суурь нь хөдөө аж ахуйн салбар бөгөөд дотоодын нийт бүтээгдэхүүний 60.3 хувийг энэ салбараас бүрдүүлж байна. Харин дотоодын нийт бүтээгдэхүүнд үйлдвэрлэлийн салбар 13.1 хувь, үйлчилгээний салбар 21.4 хувийг эзэлж байна. Сүүлийн 5 жилийн хугацаанд дотоодын нийт бүтээгдэхүүн дунджаар 59.0 тэрбум төгрөгөөр өсөж байгаа ба цаашид жил бүр өсөх хандлагатай байна.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль, дагалдан гарсан заавар журмын хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны төсвийг батлан, хууль дүрэм журмын дагуу өөрчлөлтийг оруулж, төрийн албан хаагчдын нийгмийн баталгаа болох цалин хөлс, орон нутгийн нэмэгдэл, зарим шаардлагатай хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр тусган аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлж, хэрэгжилтийг ханган ажилласан.

2024 онд улсын төсөвт 3.1 тэрбум төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 112.7 хувь, аймгийн төсөвт 30.4 тэрбум төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 108.0 хувь, сумын төсөвт 28.6 тэрбум төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 113.8 хувиар, нийт төсвийн орлогын төлөвлөгөөг 110.7 хувьтай биелүүлсэн. Аймгийн төсвийн нийт зарлага 99.3 тэрбум төгрөгөөр батлагдаж, гүйцэтгэлээр 86.4 тэрбум төгрөг зарцуулж, төсвийн



гүйцэтгэл 87.0 хувьтай гарсан. Төрийн хэмнэлтийн тухай хууль, Засгийн газраас баримталж буй бодлого, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэн ажилласан нь зардал хэмнэхэд чухал нөлөө үзүүлсэн байна.

Европын холбооны санхүүжилттэй НҮБХХ-ийн “Монгол улсад тогтвортой хөгжлийн зорилттой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төслөөс аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын дунд зохион байгуулсан “Орон нутагт үр дүнд суурилсан нэгдсэн удирдлагыг хэвшүүлэх нь” сэдэвт дэмжих хөтөлбөрт аймгийн Засаг даргын Тамгын газрын “Bulgan team” баг амжилттай оролцож, 2 дугаар байрт шалгарсан.

Төсвийн ил тод байдлыг хангаж, шилэн дансны цахим хуудсанд 33157 мэдээлэл ил тод болгохоос 32823 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, 124 байгууллага 353 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Аймгийн хэмжээнд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлэл байршуулалт 99.0 хувьтай байна.

Улсын төсвөөс эрх шилжиж ирсэн болон төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан 25.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 114 төсөл арга хэмжээнээс 101 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч шалгарч 22.7 тэрбум төгрөгийн гэрээг байгуулсан ба үүнээс 14 төсөл арга хэмжээний гүйцэтгэгчээр орон нутгийн аж ахуйн нэгж шалгарч 2.7 тэрбум төгрөгийн гэрээ байгуулсан.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу дотоодын давуу эрхийг 1 төсөл, арга хэмжээнд 47 нэр төрлийн бараанд 19.0 сая төгрөгөөр тооцуулсан. Мөн дотоодын давуу эрх тооцсоноор 2 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт бүртгэлтэй ажилгүй иргэдээс 20 хүнийг түр ажлын байраар хангахаар гэрээ байгуулан ажилласан.

Хөдөө аж ахуй

Хөдөө аж ахуйн салбарт улсын төсвийн 4.4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар хадлангийн зориулалт бүхий 11 ширхэг трактор, 16 дагалдах иж бүрдлийн хамт, 20х6 хэмжээ бүхий 23 ширхэг нарлаг хүлэмж, 32 м.кв бүхий 1000 ширхэг нарлаг хүлэмж нийлүүлэгдэж, хамгаалагдсан хөрсний үйлдвэрлэл 34760 м.кв-аар нэмэгдэж, аймгийн төвд хүлэмжийн агро парк байгуулагдах нөхцөл бүрдлээ.

Аймгийн 2024 оны мал тооллогын дүнгээр 3.0 сая толгой мал тоологдож, өмнөх онтой харьцуулахад хонь 451.0 мянга (24.2 хувь), ямаа 150.2 мянга (14.2

хувь)-аар буурч, үхэр 10.6 мянга (3.0 хувь), адуу 5.6 мянга (1.6 хувь), тэмээ 0.3 мянга (13.0 хувь)-аар тус тус өссөн байна. (Хүснэгт 4)

Хүснэгт 4. Малын тоо толгойн статистик үзүүлэлт

Малын төрөл	МАЛЫН ТОО, мянган толгой		Өөрчлөлт	
	2023	2024*	Зөрүү	Хувь
Бүгд	3622.9	3038.1	-584.8	-16.1
Тэмээ	2.0	2.3	0.3	13.0
Адуу	351.1	356.7	5.6	1.6
Үхэр	347.2	357.8	10.6	3.0
Хонь	1 866.6	1 415.6	-451.0	-24.2
Ямаа	1 056.0	905.7	-150.2	-14.2

Салбарын хүний нөөц, малчид, тариаланчдыг чадавхжуулах ажлын хүрээнд 4 удаагийн сургалт, зөвлөгөөнийг зохион байгуулж, 574 албан хаагч, малчид, тариаланчдыг хамруулж, шинээр хэрэгжиж буй бодлого чиглэл, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх талаар харилцан санал солилцлоо. Дээрх сургалт, зөвлөгөөнүүдийг зохион байгуулснаар 562 малчны хоршоо шинээр байгуулагдаж, 450 хоршоонд 56.6 тэрбум төгрөгийн зээл олгосон байна. (Зураг 33)

Зураг 33. Албан хаагчдыг чадавхжуулах сургалт



Мал аж ахуйн салбарт “Чинээлэг малчин”, “Шинэ хөдөө Булган” хөтөлбөрүүдийг хэрэгжүүлснээр өндөр ашиг шимтэй малын нийт сүрэгт эзлэх хувь хэмжээ 4.4 хувиар, бог малын амьдын жин 1-2 кг-аар, үхэр сүргийн амьдын жин 20-25 кг-аар нэмэгдэж, малчид жилдээ 300-400 толгой үржлийн хээлтэгч, хээлтүүлэгч худалдан борлуулж, 500-700 сая төгрөгийн борлуулалт хийж, эрчимжсэн аж ахуй



эрхлэгчдийг 1.1 тэрбум төгрөгийн зээл, тусламжид хамруулж, үйл ажиллагааг нь дэмжиж байна.

Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд улсын төсвийн 128.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 4 худаг, орон нутгийн төсвийн 315.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 13 худаг шинээр гаргаж, бэлчээрийн усан хангамжийг 23.8 мянган га талбайгаар нэмэгдүүлснээр 63.0 мянган толгой малыг усжуулсан байна.

Жил бүр орон нутгийн төсвийн 600-700 сая төгрөг, улсын төсвийн 200-300 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 1.2-1.3 сая толгой мал, амьтныг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулснаар өвчний тархалт 36.3 хувиар буурч, бруцеллёз өвчний халдварлалтын түвшин 0.04 хувиар буурч, нийт өвчлөлийн 0.8 хувийг эзэлж байна.

Атрын IV аяны хүрээнд 25.0 мянган га талбайг агрохимийн шинжилгээнд хамруулж, 13.1 км талбайд хамгаалалтын ойн зурвас байгуулж, тариалалтыг өмнөх оноос 12.6 га талбайгаар, ургацыг 400 тн-оор нэмэгдүүлж, аймгийн хүн амын хүнсний ногооны хэрэглээг 40.5 хувиар хангаж байна.

Үйлдвэрлэл, үйлчилгээ

Аймгийн төр, төсвийн байгууллагууд орон нутгийнхаа үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний салбарын тогтвортой үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, дотоодын зах зээлээс 2.2 тэрбум төгрөгийн худалдан авалт хийсэн байна.

Орон нутгийн үйлдвэрлэлээс сургууль, цэцэрлэгийн хэрэгцээнд 75.75 тн мах, 50.8 тн сүү сүүн бүтээгдэхүүн, 104.4 тн хүнсний ногоо, 6.4 тн жимс жимсгэнэ, 89.7 тн гурил, бүх төрлийн будааг тус тус худалдан авсан байна.

Органик бүтээгдэхүүний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд органик бүтээгдэхүүнээр баталгаажсан “Гурванборхууд” ХХК-ийн “Халтар арвайн гурил”, “Сүргийн нуга” ХХК-ийн “Зөгийн бал” бүтээгдэхүүнийг бүртгэж, хаяг шошгонд “Органик бүтээгдэхүүн”-ий тэмдэглэгээг байршууллаа. (Зураг 34)

Зураг 34. Органик бүтээгдэхүүнээр баталгаажсан брэнд



Хэрэглэгчдийг чанартай, аюулгүй, баталгаатай бүтээгдэхүүн, үйлчилгээгээр хангах, орон нутгийн үйлдвэрлэл үйлчилгээний өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, брэнд бий болгоход чиглэсэн аймгийн Засаг даргын нэрэмжит “Чанарыг эрхэмлэгч үйлдвэрлэгч”-ээр Булган сумын “Хатан мээж хайрхан” ХХК-ийн “Мээжийн сүү” үйлдвэр, “Чанарыг эрхэмлэгч үйлчилгээ”-ний байгууллагаар Сэлэнгэ сумын “Соргог ланд” ХХК-ийн “Долоон нуга” аялал жуулчлалын газар шалгарсан. (Зураг 35)

Зураг 35. “Чанарыг эрхэмлэгч үйлдвэрлэгч”



Бүрэгхангай сум орон нутгийн хөгжлийн сангийн 171.5 сая төгрөгийн санхүүжилтээр халуун ус, саун, үсчин гоо сайхан зэрэг 5 хүнд зэрэг үйлчлэх боломжтой цэг ашиглалтад оруулав. Мөн Сайхан сум орон нутгийн төсвийн 65.0 сая төгрөгөөр халуун усны барилга шинээр барьж 2 дүүш, 1 үсчний суудалтай, боловсон бие засах цэг бий болгов. (Зураг 36)

Зураг 36. Халуун усны барилга



Гурванбулаг суманд ахуйн үйлчилгээний хуучин байранд орон нутгийн төсвийн 745.0 сая төгрөгөөр их засвар хийн төвлөрсөн дулаанд холбож, 11 өрөөнд үсчин, гоо сайхан, оёдол, эмийн сан, сургалт, чийрэгжүүлэлт, худалдаа үйлчилгээний чиглэлээр түрээсээр ажиллуулж байна. (Зураг 37)

Зураг 37. Ахуйн үйлчилгээний барилга



Рашаант сум орон нутгийн хөгжлийн сангийн 35.0 сая төгрөгөөр халуун усны барилгад засвар хийж, ашиглалтад оруулав. (Зураг 38)

Зураг 38. Халуун усны барилга



Тэшиг сумын халуун усны барилгад орон нутгийн хөгжлийн сангийн 251.7 сая төгрөгөөр капитал засвар хийж, саун, үсчин, гоо сайхан, нийтийн бие засах газар, халуун усны 5 өрөөг ашиглалтад оруулсан. (Зураг 39)

Зураг 39. Халуун усны барилга



Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар улсын аялал жуулчлалын гол бүс Булган-Хөвсгөл чиглэлд “Их Ачуут констракшн” ХХК, Рашаант-Элсэн тасархай чиглэлд “Девелопмент лорд” ХХК “MARS TOURIST STATION”, Орхон суманд “Өлзийт хангал” ХХК зочид буудал, зоогийн газар бүхий үйлчилгээний цогцолбор



шинээр бүтээн байгуулж, Хутаг-Өндөр, Тэшиг сумын нутагт “Бүтэлэ”, Сэлэнгэ суманд “Seven nuga”, Бүрэгхангай суманд “Ихэр тавилан” амралтын газрууд, аймгийн төвд “Авзага трэйд” ХХК 120 хүний хүчин чадалтай “Дайчин ван” зочид буудал, “Элбэг Эд” ХХК 100 хүний хүчин чадалтай VIP үйлчилгээ бүхий зоогийн газар, караоке баар, “Булган Анар” ХХК “World wine” дарсны төрөлжсөн цэг, Хялганат тосгонд “ОХОТ” ХХК зочид буудал, зоогийн газар зэрэг үйлдвэрлэл үйлчилгээний цэгүүд тогтвортой үйл ажиллагаа явуулж, аймгийнхаа нийгэм, эдийн засагт үр өгөөжтэй ажиллаж байна. (Зураг 40, 41)

Зураг 40. “Девелопмент лорд” ххк “Mars tourist station”



Зураг 41. “Өлзийт хангал” ХХК -ийн “Чулуут ам буфет”



Орон нутгийн үйлдвэрлэгчдийн борлуулалтыг нэмэгдүүлэх зорилготой “Амар байна уу”, “Миний Булганы Алтан намар” үзэсгэлэн худалдааг зохион байгуулж, 10 сумын, 40 аж ахуйн нэгж, иргэн 20 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнээр оролцож, үйлдвэрлэгчид 131.9 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна. (Зураг 42)



Зураг 42. "Амар байна уу"




Аймгийн Засаг даргын захирамжаар “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, төсөл сонгон шалгаруулах дэд хороо”-г байгуулж, сангийн эх үүсвэрт багтаан тэргүүлэх чиглэлийн хүрээнд эрэмбэлэлт хийж, 10 төсөл 920.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамрагдаж, шинээр 38 ажлын байр бий болж, 33 ажлын байр хадгалагдан үлдсэн байна.

Хоршоо хөгжүүлэх санд 1.3 тэрбум төгрөг эргэн төлөгдөж, Булган, Орхон, Бүрэгхангай, Гурванбулаг, Рашаант, Хангал, Сэлэнгэ сум 19 хоршоонд 705.5 сая төгрөгийн зээл олгож, 33 ажлын байр шинээр бий болж, 76 ажлын байр хадгалагдан үлдсэн.

“Шинэ хоршоо” хөдөлгөөний хүрээнд шинээр 509 малчны хоршоо байгуулагдаж, 5091 малчин хоршоонд нэгдэж, 120 хоршооны мэдээлэлд өөрчлөлт хийгдэж, бүртгүүлсэн байна. Мөн 1390 малчин 3 хувийн хүүтэй 5 жилийн хугацаатай 51.4 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамрагдав. Үүнээс 332 малчны 12.6 тэрбум төгрөгийн зээлийн 10-100 хувьд 8.4 тэрбум төгрөгийн батлан даалт гаргасан байна. (График 9)

График 9. Сумдад үйл ажиллагаа явуулж буй хоршоодын тоо



“Батлан даалтын сан”-д ипотекийн орон сууцны зээлийн урьдчилгаа төлбөрт 32 иргэний 1.1 тэрбум төгрөгийн 60 хүртэл хувьд буюу 678.3 сая төгрөгийн батлан даалт гаргаж гурвалсан гэрээг баталгаажууллаа.

Орхон аймагт 2024 оны 04 дүгээр сарын 18-22-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Монгол үндэстний хоол, идээ ундааг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх зорилго бүхий “Улсын аварга тогооч” шалгаруулах ур чадварын уралдаан, спортын анхдугаар их наадамд аймгийн Тогооч нарын холбоо оролцож, шилдгийн шилдэг “Гранпри цом”-ын төлөөх “Хар хайрцагны баг”-ийн төрөлд 3-р байр эзлэв. Улсын тогоочдын зөвлөгөөнд аймгийн тогоочдын төлөөлөл амжилттай оролцож, Булганы нэрийн хоол “Тэргүүн шимт” хоолны амталгаа хийж сурталчлав. (Зураг 43)

Зураг 43. “Улсын аварга тогооч” шалгаруулах ур чадварын уралдаан



Орон нутгийн төсвийн 15.0 сая төгрөгөөр уртын хэмжлийн болон согтуурлын зэрэг тогтоох драйгер баталгаажуулах эталон худалдан авч хэмжил зүйн лабораторийн эталоны хангамжийг нэмэгдүүлж, шинээр ажлын уртын 5, амьсгал дахь спиртийн агууламж тодорхойлох 15 драйгер баталгаажууллаа. (Зураг 44)

Зураг 44. Уртын хэмжлийн эталон, Драйгер хэмжигч эталон.



Орон нутгийн төсвийн 10.0 сая төгрөгөөр сорилтын лабораторид жимс, хүнсний ногооны пестицидийн үлдэгдэл тодорхойлогч багаж, ус нэрэгч, PH метр,

суурин компьютер худалдан авч хүнсний аюулгүй байдлыг хангах шинжилгээний үзүүлэлтийг нэмэгдүүлэв. (Зураг 45)

Зураг 45. Пестицидийн үлдэгдэл тодорхойлогч багаж хэрэгсэл



Хэмжих хэрэгслийн баталгаажуулалтаар 16 сум, 1 тосгонд ажиллаж 3176 ширхэг хэмжих хэрэгслийг технологийн хугацаанд баталгаажуулж, төлөвлөгөөг 580 хэмжих хэрэгслээр нэмэгдүүлэв. (Зураг 46)

Зураг 46. Баталгаажуулалтын ажлын явц



НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Байгаль орчин

Хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулах, эх үүсвэр дээр нь ангилан ялгах, дахивар нөөц цуглуулах зорилгоор хог ангилан ялгах 200 ширхэг хогийн савыг Булган сумын гэр хорооллын айл өрхүүдэд суурилуулж дуусгаснаар иргэд хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах боломж бүрдсэн. Тус ажлыг байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын 171.0 сая төгрөгөөр хийж гүйцэтгэлээ.

Хатуу хог хаягдлыг ангилан ялгах, боловсруулах зорилгоор хог түрж булах ковш Орхон, Бугат суманд, экскаватор Баян-Агт, Тэшиг суманд, хог, зам цэвэрлэгээний тусгай зориулалтын ковш Хялганат тосгонд, хог хаягдлыг ачиж, тээвэрлэх Япон стандартын автомашиныг Булган, Хангал суманд, бохир соруулах

тоноглогдсон автомашиныг Булган, Баян-Агт, Сэлэнгэ суманд, Нэгдсэн эмнэлгийн аюултай хог хаягдлыг ариутган халдваргүйжүүлэх автоклавыг байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын 863.1 сая төгрөгөөр нийлүүлсэн. (Зураг 47)

Зураг 47. Сумдад олгогдсон техник хэрэгсэл



“Цэвэр орчин-цэмцгэр Булган” аяныг аймгийн хэмжээнд жил бүр зарлаж, нийтийг хамарсан хог цэвэрлэгээний ажлыг 3 удаа зохион байгууллаа. Аяны хүрээнд 16 сум орчны бохирдлыг бууруулах цэвэрлэгээний ажлыг зохион байгуулж, 49471.3 га талбайгаас 6822.4 тонн, 124 гол горхи уст цэгийн орчмоос 2003.2 тонн хог хаягдлыг цэвэрлэж, 1401 золбин муур нохой, 496264 сэг зэмийг устгаж, ариутгаж дарж булсан. Цэвэрлэгээний ажилд давхардсан тоогоор 278 аж ахуйн нэгж, 7308 иргэн буюу нийт аж ахуйн нэгж өрхийн 75-аас доошгүй хувь оролцож, 371 техник ашиглалаа.


2024 онд химийн аюултай хог хаягдлын тооллого хийгдэж, аймгийн хэмжээнд 7 ерөнхий боловсролын сургууль, 3 лабораторийн 543.5 кг хугацаа дууссан устгах шаардлагатай химийн бодисыг нэр төрөл бүрээр дахин бүртгэлжүүлэн, мэргэжлийн байгууллагаар устгууллаа.

Аймгийн ан агнуурын зохион байгуулалтын ерөнхий судалгааг хийж, 2024-2028 оны менежментийн төлөвлөгөөг боловсрууллаа. “Монгол тарвага” сэргээн



нутагшуулах ажил, аймгийн ан агнуурын менежментийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Дашинчилэн сумын ургамлын бүрхэвч болон амьдрах орчны нөхцөлийг судалсны үндсэн дээр 40 тарвагыг нутагшуулав. (Зураг 48)


Зураг 48. Ан агнуурын менежментийн төлөвлөгөө



Усны сан бүхий газрын энгийн болон онцгой хамгаалалтын бүсэд 200 ширхэг тэмдэгжүүлэлт суурилуулах ажлыг аймгийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын 39.9 сая төгрөгийн хөрөнгөөр хийж гүйцэтгэв.

Ойн хөнөөлт хортон шавьжны судалгааны ажлыг 919200 га талбайд хийж, 2025 онд тэмцэл явуулах урьдчилсан талбайг гаргалаа. Ойн хортны тэмцлийн ажлыг 23500 га талбайд байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын 759.7 сая төгрөгөөр хийж гүйцэтгэлээ. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Орхон, Хутаг-Өндөр, Бугат суманд 20 га талбайд ойжуулалт хийж, аймгийн хэмжээнд 466379 ширхэг мод тарьж ургуулсан. (График 10)

График10. Ойн ажлын үзүүлэлт



Аялал жуулчлал

2024 онд 5 эвент арга хэмжээг төлөвлөн "Хангинахын шугуйн шагайн тойром", "Алтаргана 2024" олон улсын наадам, "АЙРАГ НААДАМ", "Airagday", "ITM Mongolia" арга хэмжээг тус тус зохион байгууллаа. Эдгээр эвент арга хэмжээг давхардсан тоогоор гадаадын 19360, дотоодын 267820 орчим аялагчид үзэж сонирхохоор зорин ирсэн байна. Дээрх арга хэмжээнүүдэд оролцогчдын тоо өмнөх онтой харьцуулахад 13.0 хувиар өссөн дүнтэй байна. (Зураг 49)

Зураг 49. Эвент арга хэмжээ



Уул уурхай

Бүрэгхангай суманд уул уурхайн олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа тусгай зөвшөөрөл эзэмшигч "Өгөөж баянхангай" ХХК, "Платинум Ланд" ХХК, "Гэрэлт шинэчлэл" ХХК, "Хос хас" ХХК-тай нийгмийн хариуцлагын гэрээ байгуулж, хүүхдийн боловсролыг дэмжих асуудлаар 126.0 сая төгрөгийг аймгийн Засаг даргын Тамгын газрын нөөц хөрөнгөд төвлөрүүлсэн.



“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд аймгийн нутаг дэвсгэрт уул уурхайн олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа Бүрэгхангай сумын “Өгөөж баян хангай” ХХК 1000 ширхэг, “Хос Хас” ХХК 5000 ширхэг, “Хан тэнгэрийн дуудлага” ХХК 500 ширхэг, “Платинум ланд” ХХК 40000 ширхэг, “Эрхэс майнинг” ХХК 2000 ширхэг, “Мөнхнархан орд” ХХК 1000 ширхэг мод, бут, сөөг нийт 49500 ширхэг мод тарьж ургуулан, амьдралт 80 хувьтай байна.

Бүрэгхангай сумын Дэрст багийн нутаг дэвсгэрт уул уурхайн төсөл хэрэгжүүлэгч 9 аж ахуйн нэгж техникийн нөхөн сэргээлт 52.4 га, биологийн нөхөн сэргээлт 30.32 га талбайд хийхээр төлөвлөж, 63.4 га талбайд техникийн нөхөн сэргээлт, 55.4 га талбайд биологийн нөхөн сэргээлт хийсэн.

Дэд бүтцийн төлөвлөлт, төв суурингийн хөгжил

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд 54 төсөл арга хэмжээ тусгагдсанаас 5 ажил өнгөрсөн оны өр, 3 ажил гүйцэтгэгч шалгараагүй, 37 ажилд комисс ажиллаж байнгын ашиглалтад оруулсан бөгөөд 9 ажил он дамнан хэрэгжиж байна. (Зураг 50, 51, 52, 53, 54)

Зураг 50. Орхон сумын соёлын төвийн засвар



Зураг 51. Булган сумын соёл амралтын цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт



Зураг 52. Сургуулийн биеийн тамирын талбайн тохижилт



2024 онд орон нутгийн төсвийн 622.0 сая төгрөгөөр "Сервис по сименс" ХХК шалгарч Булган сумын 1 болон 5, 6 дугаар багт гэрэлтүүлгийн ажил хийж ашиглалтад оруулан Булган сумын төвийн суурьшлын бүсийн гэрэлтүүлэг 9.0 хувиар нэмэгдэж, 20.0 хувьд хүрч хотын өнгө үзэмж, иргэдийн аюулгүй орчинд амьдрах орчин нөхцөл бүрдлээ. (Зураг 53)

Зураг 53. Булган сумын төвийн суурьшлын бүсийн гэрэлтүүлэг



2024 онд Хутаг-Өндөр суманд 534.4 сая төгрөгөөр 640 м, Орхон суманд 827.7 сая төгрөгөөр 867 м, Рашаант суманд 500 сая төгрөгөөр 520 м авто замыг "Энх-Алтаргана" ХХК тус тус гүйцэтгэж, Бугат суманд 300 сая төгрөгөөр "Ингүүмэл зам" ХХК хатуу хучилттай авто замын үргэлжлэлийг барьж гүйцэтгэн улсын комисст тус тус хүлээлгэн өгсөн. (Зураг 54)

Зураг 54. Сумын төвүүдийн авто замын ажил





ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

“Цахим Монгол” төрийн шуурхай үйлчилгээ

Цахим гарын үсгийн тухай хууль болон "Цахим Монгол" төрийн үйлчилгээг орон нутагт үр дүнтэй хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2024 онд аймгийн хэмжээнд 30844 иргэнд тоон гарын үсэг олгосон байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 34.5 хувиар өссөн байна.

Төрийн болон хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар болон “Гэрэгэ системс” ХХК хамтран Булган аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтэст төрийн үйлчилгээг хурдан шуурхай, хүртээмжтэй хүргэх зорилгоор 15 ширхэг киоск машиныг хүлээлгэн өгсөн. Үүнээс 11 киоск машиныг сумдад, 4 киоск машиныг аймгийн төвд тус тус байршуулсан.

Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар, Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв улсын төсөвт үйлдвэрийн газар хамтран “Цахимд зөв байя” уриатай Кибер аюулгүй байдлын тухай цахим ур чадвар олгох III шатны сургалтад 3764 иргэнийг хамрууллаа.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах зорилгоор аймгийн Засаг даргын Тамгын газрын вэб сайт (www.bulgan.gov.mn)-ын ашиглалтыг сайжруулж, баяжилтыг хийж иргэд олон төрлийн мэдээллийг нэг дороос авах боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.

Нээлттэй мэдээллийн нэгдсэн сан (www.shilen.gov.mn)-д агентлаг, сумдууд үе шаттайгаар өөрийн байгууллагын тайланг тайлагнаж, 2024 оны жилийн эцсийн байдлаар 40 байгууллага (www.shilen.gov.mn) бүртгэгдсэн байгаа бөгөөд 33 байгууллагын баталгаажуулалт хийгдсэн. (Зураг 55)

Зураг 55. Нээлттэй мэдээллийн нэгдсэн сан дахь байгууллагын мэдээлэл

№	Байгууллагын нэр	Тайлант үе	Хувиар	Төлөв	Тайлант огноо	Индексийн үзүүлэлт (Баталгаасан)	Үйлдэл
1	Булган аймгийн Орон нутгийн өмчийн газар	2024 оны 4 улирал	3	Баталгаасан	2024-12-25	92.84%	Тайланг харах
2	Булган аймгийн Булган сумын засаг даргын Тамгын газар	2024 оны 4 улирал	2	Баталгаасан	2024-12-25	71.13%	Тайланг харах
3	Булган аймгийн Мандал сумын Засаг даргын Тамгын газар	2024 оны 4 улирал	2	Баталгаасан	2024-12-13	61.06%	Тайланг харах
4	Булган аймгийн Халдус сумын Засаг даргын Тамгын газар	2024 оны 4 улирал	2	Баталгаасан	2024-12-13	47.08%	Тайланг харах
5	Булган аймгийн Баянхүү сумын Засаг даргын Тамгын газар	2024 оны 4 улирал	3	Баталгаасан	2024-12-11	0%	Тайланг харах
6	Булган аймгийн Худалдан авах ажиллагааны газар	2024 оны 4 улирал	3	Баталгаасан	2024-12-10	0%	Тайланг харах
7	Булган аймгийн соёл, урлагийн газар	2024 оны 4 улирал	2	Баталгаасан	2024-12-10	0%	Тайланг харах
8	Булган аймгийн Баянхүү сумын Засаг даргын Тамгын газар	2024 оны 4 улирал	2	Баталгаасан	2024-12-11	25.85%	Тайланг харах
9	Булган аймгийн Халдус сумын тосгоны захиргааны ажлын алба	2024 оны 4 улирал	2	Баталгаасан	2024-12-10	0%	Тайланг харах
10	Булган аймгийн Санхүүгийн хэлтэс, дотгоо, аудитын алба	2024 оны 4 улирал	3	Баталгаасан	2024-12-10	92.48%	Тайланг харах

Мэргэшсэн, ёс зүйтэй төрийн алба, хүнд сурталгүй төрийн үйлчилгээ

2024 онд давхардсан тоогоор 11071 албан хаагч Төрийн албаны тухай хууль, тогтоомжийн хүрээнд мэргэшүүлэх багц цагийн болон бусад чадавхжуулах



сургалтад хамрагдсан. Мөн боловсролын зэргээ ахиулахаар 14 албан хаагч суралцаж байна.

Төрийн албаны тухай хуульд заасан мэргэшүүлэх багц цагийн сургалтад төлөвлөгөөний дагуу төрийн албанд анх томилогдсоны дараах чиглүүлэх богино хугацааны сургалтад 6, мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 1, мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад 17, ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц цагийн сургалтад 10, эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц цагийн сургалтад 1 албан хаагч тус тус суралцаж байна.

Төрийн албаны зөвлөлийн Булган аймаг дахь салбар зөвлөлөөс төрийн албаны нөөц бүрдүүлэх ерөнхий шалгалтыг 3, 5, 9, 11 дүгээр сард 4 удаа төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, төрийн албаны ерөнхий шалгалтын дүнгээр 91 иргэн нөөцөд бүртгэгдсэн.

2024 онд төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагч, төрийн захиргааны гүйцэтгэх албан тушаалын 145 сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалт, тусгай шалгалтыг 8 удаа зохион байгуулсан.

2024 онд “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль”-ийн сургалтыг Төрийн албаны зөвлөлийн Булган аймаг дахь салбар зөвлөлтэй хамтран 151 төрийн байгууллагын 4000 гаруй албан хаагчдад зохион байгууллаа.

Булган аймагт үйл ажиллагаа явуулж буй нийт төрийн байгууллагуудын ёс зүйн дэд хороог “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль”-ийн дагуу байгуулан ажиллаж байгаа эсэхэд хяналт хийхэд хүчингүй болсон эрх зүйн акт үндэслэсэн, хамт олноос санал хураагаагүй зэрэг зөрчил илэрснийг “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль”-д нийцүүлж байгуулахад арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллалаа.
(Зураг 56)

Зураг 56. Дэд хороо (салбар тус бүрээр)



2024 оны 11 дүгээр сарыг аймгийн хэмжээнд “Ёс зүйтэй, мэдлэг чадвартай, хариуцлагатай төрийн алба”-ны сарын аян болгон зарласан. Сарын аяны хүрээнд агентлаг, сум бүр төрийн албан хаагчдын ёс зүй, мэдлэг, ур чадварыг сайжруулах,



мэргэшүүлэх, чадвар, дадлыг дээшлүүлэх талаар тодорхой үр дүнд хүрсэн ажлуудыг төлөвлөгөө гарган зохион байгуулж, нийт 22.5 сая төгрөг зарцуулсан. (Зураг 57)

Зураг 57. Сарын аяны хүрээнд зохиогдсон уралдаан тэмцээн



Бүгд Найрамдах Солонгос улсын Кёнги аймгийн Шинхан Их Сургуульд манай аймгийн 66 оюутан 100 болон 70 хувийн тэтгэлэгтэйгээр эдийн засаг, аялал жуулчлалын салбарын мэргэжлээр амжилттай суралцаж байна. Мөн Жэжү мужид зохион байгуулагдсан “Тамна” ОУ-ын фестивалд соёлын байгууллагын уран бүтээлчид оролцож, эх орныхоо урлаг соёлыг сурталчлан, бусад олон орны соёлоос туршлага судалсан байна. БНСУ-д байршилтай Зүүн Хойд Азийн Нутгийн Захиргаадын Холбоо (NEAR)-оос зохион байгуулсан 6 удаагийн олон улсын арга хэмжээнд 15 төрийн албан хаагч оролцож, туршлага солилцсон.

ОХУ-ын Буриад улсын Засгийн газартай боловсрол, соёлын хамтын ажиллагааг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, “Алтаргана-2024” олон улсын наадмыг амжилттай зохион байгуулсан. Тус улсын Хөдөө аж ахуйн их сургуульд манай аймгийн 17 оюутан малын эмчийн мэргэжлээр суралцаж байна.

Хууль, эрх зүй, батлан хамгаалах

“Бүх нийтийн эрх зүйн боловсрол, ”Зөв дадал-Архигүй орчин” хөтөлбөрүүдийн хүрээнд 2024 онд орон нутгийн төсвөөс 20.0 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэж, хэрэгжүүлэв. Мөн Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор орон нутгийн төсвөөс 10.0 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэсэн.

Төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран хэрэгжүүлж буй хөтөлбөрийн болон гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд 2024 онд “Хүүхэд хамгаалал”, “Хяналт-Зөвлөмж”, “Хувийн хэрэг”, “Уусан бол бүү жолоод”, “Захирамж”, “Согтуу”, “Гэр бүлийн үнэ цэнэ”, “Дээрэлхэл дэлгэрэх ёсгүй”, “Байгалиа хамгаалья”, “Мал, мах-2024”, “Ногоон гэрэл цагаан шугам-2024”, “Цагаан толгой-



2024", "Камер ажиллаж байна" зэрэг 34 нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулсан.

2024 онд төрийн болон хувийн хэвшлийн 6 байгууллагын 13 ширхэг хяналтын камерыг Цагдаагийн газрын серверт холбосон.

2024 онд улсын болон орон нутгийн төсвөөс Цагдаагийн газарт Рашаант суманд 60.0 сая төгрөгөөр, Могод суманд 26.5 сая төгрөгөөр, Булган суманд 27.0 сая төгрөгөөр тус тус шинээр тээврийн хэрэгсэл худалдан авч, Сайхан, Гурванбулаг сум, Хялганат тосгоны албаны тээврийн хэрэгслийн урсгал засварт 1.78 сая төгрөг, Замын цагдаагийн тасагт land cruiser-76 маркийн тээврийн хэрэгслийг 26.0 сая төгрөгөөр, Шүүх шинжилгээний хэлтэст 1 тээврийн хэрэгслийг тус тус шийдвэрлэж албан хэрэгцээнд ашиглаж байна.

"Зөв дадал-Архигүй орчин" хөтөлбөрийн хүрээнд аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, аймгийн Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн газар, Цагдаагийн газар хамтран 12 иргэнийг албадан эмчилгээнд хамруулахаар Төв аймагт байрлах "Согтуурах, мансуурах донтой иргэдийг албадан эмчлэх газар"-т хүлээлгэн өгсөн.

"Устгал" арга хэмжээний хүрээнд "Каннабис" ургамлыг устгах ажлыг зохион байгууллаа. Аймгийн хэмжээнд мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм ханган нийлүүлэх, үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй 1 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулдаг ба тухайн байгууллагын эмийн эргэлтэд хяналт тавин ажилласан. Энэ онд мансуурах зорилгоор хууль бусаар мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм авч ашигласан гэмт хэрэг бүртгэгдээгүй байна.

Хууль бусаар алт олборлох, хуш модны самар түүх зорилгоор хилийн зурвас, бүсэд зөвшөөрөлгүй нэвтэрсэн 4 удаагийн 47 хүний зөрчлийг илрүүлэн, хуулийн дагуу шийдвэрлэсэн. Хил орчмын дэглэмийн зөрчил өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 71.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

2024 онд 16 сумын хэмжээнд 110.0 сая төгрөгийн багаж зэвсэглэмжээр гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, сайн дурын хүчнийг хангаж, чадавхжуулах дадлага сургуулийг зохион байгуулж ажилласан.

Орон нутгийн хамгаалалтын тухай хууль, Батлан хамгаалахын сайдын 2024 оны А/110 дугаар тушаал, Монгол Улсын Засгийн газрын батлан хамгаалах зарим чиг үүргийг Булган аймагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээ, Цэргийн штабын сургалтын нэгдсэн төлөвлөгөө, аймгийн Засаг даргын захирамжийн дагуу орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн удирдах бүрэлдэхүүний "Хээрийн дадлага" сургалтыг 2024 оны 06 дугаар сарын 29-нөөс 07 дугаар сарын 05-ны өдрүүдэд



Сайхан сумын эрээний уурхайг түшиглэн зохион байгуулж, нийт 170 гаруй хүн хамрагдсан.

БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Хутаг-Өндөр сумын "Булган мах маркет" ХХК БНХАУ, Иран улсуудад 495 тн мах экспортод нийлүүлж, дотоодын зах зээлд 250 тн мах бэлтгэн, мал сүргийг эдийн засгийн эргэлтэд оруулж байна.

Булган сумын 5 дугаар багт Иргэн Ш.Баттөр хувийн хөрөнгө оруулалтаар 56 айлын орон сууцны барилга барьж, 2024 оны 2 дугаар улиралд, "Нүнжиг өргөө" ХХК өөрийн хөрөнгөөр 25 айлын нийтийн орон сууцны барилга барьж, 2024 оны 6 дугаар сард ашиглалтад оруулсан. Булган сумын 6 дугаар багт "Их ураг" ХХК өөрийн хөрөнгөөр үйлчилгээ бүхий 25 айлын орон сууцны 2 дахь блокын барилгыг 2024 оны 3 дугаар улиралд, Булган сумын 2 дугаар багт "Хурмастын хүлэг" ХХК хувийн хөрөнгө оруулалтаар 25 айлын 5 давхар нийтийн орон сууцны барилгыг 2024 оны 4 дүгээр улиралд тус тус ашиглалтад оруулсан.

2024 онд Хангал сумын цэвэр усны 3 дугаар шатны ажилд 300.0 сая төгрөг, Сэлэнгэ сумын төвийн цэвэр усны шугамын ажил 1470.0 сая төгрөг, Хангал сумын Хялганат тосгоны инженерийн шугам сүлжээний өргөтгөл 335.0 сая төгрөг, Сайхан сумын цэвэр усны 4 дүгээр шатны ажилд 550.0 сая төгрөг, Баян-Агт сумын ариутгах татуургын шугамын өргөтгөл 282.0 сая төгрөг, Сайхан сумын төвийн ариутгах татуургын шугамын өргөтгөл 292.0 сая төгрөг, Бүрэгхангай сумын дулаан хангамжийн угсралтын ажилд 70.0 сая төгрөг тус тус тусгагдаж, ашиглалтад оруулав.



1.5. Булган аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ

Аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн 45 үзүүлэлтийн биелэлтийг 2024 оны жилийн эцсийн байдлаар тооцож үзэхэд 90.4 хувьтай байна. Үүнээс эдийн засгийн хөгжлийн үзүүлэлт 84.3 хувь, нийгмийн хөгжлийн үзүүлэлт 96.0 хувьтай тус тус хэрэгжжээ. Энэхүү үзүүлэлтүүдийн биелэлтийг аймгийн Статистикийн хэлтэс болон холбогдох байгууллагуудаас авч үнэллээ. (Хүснэгт 5)

Хүснэгт 5. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь үзүүлэлт	Зорилтот түвшин	Гүйцэтгэл	Хувь
			2020	2024		
ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ						
1	Дотоодын нийт бүтээгдэхүүн	сая төгрөг	399,410.8	461,000.0	630,107.8	100
2	Нэг хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүн	сая төгрөг	6.5	7.4	10.3	100
3	Төсвийн орлого	сая төгрөг	69,676.2	70,000.0	91,516.3	100
4	Төсвийн зардал	сая төгрөг	64,455.7	69,500.0	86,435.9	100
5	Төсвийн тэнцэл		5220.5	500.0	5,080.4	100
6	Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн эргэн төлөлтийн хувь	хувь	97.2	100	57.5	30
7	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн эргэн төлөлтийн хувь	хувь	66.1	80.0	83.0	100
8	Ажилгүйдлийн түвшин	хувь	12.2	7.5	4.2	100
9	Ажиллах хүчний оролцооны хувь	хувь	60.5	64.5	65.5	100
10	Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан иргэдийн нийт хүн амд эзлэх хувь	хувь	87.3	90.0	87.0	30
11	Эдийн засгийн идэвхтэй хүн ам /ажиллах хүч/-ын нийгмийн даатгалд эзлэх хувь	хувь	65.6	75.0	81.0	100
12	Шинээр бий болгосон байнгын ажлын байрны тоо	тоо	198	400	411	100
13	Хэрэглээний үнийн индекс	индекс	1.8	2.6	5.5	50
14	Малын тоо	мянган толгой	3,395.7	3171.3	3038.1	100
15	Хураан авсан үр тариа	мянган тонн	47.4	55	64.5	100



16	Хураан авсан малын тэжээл бусад	мянган тонн	8.0	10	15.4	100
17	Хураан авсан хүнсний ногоо	мянган тонн	1.9	3.5	2.2	30
18	Хүлээн авах гадаад жуулчдын тоо	тоо	7000	15000	17500	100
19	Идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагын тоо	тоо	1239	1350	1053	30
20	Инженерийн бүрэн хангамжтай орон сууцаар хангагдсан өрхийн нийт өрхөд эзлэх хувь	хувь	2.5	2.9	7.4	100
21	Цахилгаан эрчим хүчээр хангагдсан хүн амын эзлэх хувь	хувь	98.5	98.9	98.9	100
НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ						
22	Хүн амын дундаж наслалт	тоо	73.5	74.0	74.37	100
23	Хүний хөгжлийн индекс	индекс	0.677 /2019/	0.690	0.745	100
24	Жендерийн тэгш бус байдлын индекс	индекс	0.821	0.825	0.806	100
25	Бүртгэгдсэн гэмт хэрэг	тоо	350	300	411	30
26	Иргэдэд учирсан хохирлын нөхөн төлүүлэлтийн түвшин	хувь	54	60	61.9	100
27	PM2.5 тоосонцрын жилийн дундаж агууламж	м кг/м3	-	-	43	100
28	PM10 тоосонцрын жилийн дундаж агууламж	м кг/м4	-	-	-	-
29	Ойгоор бүрхэгдсэн талбайн эзлэх хувь	хувь	39.4	39.8	39.8	100
30	Дахин боловсруулах хог хаягдлын эзлэх хувь	хувь	5	15	15.6	100
31	Хот суурин газрын тогтмол цуглуулж, шаардлага хангасан байдлаар устгах хог хаягдлын эзлэх хувь	хувь	70	80	80	100
32	100000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдлийн түвшин	промилль	0	0	0	100
33	1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдлийн түвшин	промилль	16.2	16.0	10.6	100
34	10000 хүн амд вируст гепатитын өвчлөл	тоо	1	1	0	100



35	Тухайн жилийн товлोलт дархлаажуулалтад хамрагдсан хүүхдийн эзлэх хувь	хувь	94.0	96	96.8	100
36	Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлгийн хамралтын хувь	хувь	77.2	81.0	82.0	100
37	Чихрийн шижин өвчний үеийн эрт илрүүлгийн хамралтын хувь	хувь	76.7	80.0	90.0	100
38	Хорт хавдрын эрт илрүүлгийн хамралтын хувь	хувь	70.5	78	80.0	100
39	Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын цэвэр жин	хувь	59.3	64.3	70.9	100
40	Суурь боловсролын хамран сургалтын цэвэр жин	хувь	86	90.9	89.96	80.8
41	Цэцэрлэгийн бүлгийн нэг багшид ногдох хүүхдийн тоо	тоо	30	25	24.4	100
42	Бага ангийн нэг багшид ногдох хүүхдийн тоо	тоо	25-28	25	24.9	100
43	Элсэлтийн ерөнхий шалгалтын дундаж оноо	тоо	474	510	509	97.2
44	Оюутан цэрэг сургалтад хамрагдах суралцагчдын тоо	тоо	0	10	10	100
45	Төрийн цахим үйлчилгээний тоо	тоо	383	480	800	100
Дундаж						90.4

Аймгийн ДНБ 630.1 тэрбум төгрөгт хүрч, 2020 оны суурь түвшинтэй харьцуулахад 57.7 хувиар, 2024 оны зорилтот түвшнээс 36.7 хувиар өссөн байна. Мөн нэг хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүн 10.3 сая төгрөгт хүрч, суурь түвшнээс 3.8 сая төгрөгөөр нэмэгдэж, зорилтот түвшнээ хангажээ.

Аймгийн орон нутгийн төсвийн орлого 91.5 тэрбум төгрөгт хүрч, зорилтот түвшнээ хангаж, бүх төр, төсвийн байгууллагууд батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулсан.

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн эргэн төлөлт 57.5 хувьтай байна. Аймгийн хэмжээнд жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сангаас 32 төсөл дэмжлэг авснаас 27 төсөл хэвийн, 1 төсөл хэвийн бус, 1 төсөл эргэлзээтэй, 3 төсөл муу зээлийн ангилалд багтаж байна.



Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн зээл төлөлт 83.0 хувь, ажилгүйдлийн түвшин 2023 оны жилийн эцсийн байдлаар 5.9, 2024 оны 3 дугаар улирлын байдлаар 4.2 хувьд хүрч 2024 оны зорилтот түвшиндээ тус тус хүрсэн байна.

Ажиллах хүчний оролцооны түвшин 2023 оны жилийн эцсийн байдлаар 65.5, 2024 оны 3 дугаар улирлын байдлаар 62.0 хувьтай байна.

Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан иргэдийн нийт хүн амд эзлэх хувь өмнөх оноос 0.3 пунктээр буурч, эдийн засгийн идэвхтэй хүн амын нийгмийн даатгалд эзлэх хувь өмнөх оноос 36.6 пунктээр нэмэгдэж 81.0 хувьд хүрсэн байна.

2024 онд 400 байнгын ажлын байр бий болгохоор төлөвлөж, 411 байнгын ажлын байр бий болжээ.

Хэрэглээний үнийн индекс 5.5 хувьтай гарч, зорилтот түвшнээсээ 2.9 пунктээр нэмэгдсэн нь өргөн хэрэглээний барааны үнэ 2 дахин нэмэгдэхэд нөлөөлсөн байна.

2024 оны жилийн эцэст 3038.1 мянган толгой мал тоолуулсан нь өмнөх оноос малын тоо буурч, малчид бэлчээрийн даацад тохируулан малаа эдийн засгийн эргэлтэд оруулж, зорилтот түвшиндээ хүрчээ.

Хөдөө аж ахуйн чиглэлээр хураан авсан үр тариа, малын тэжээл бусад таримлын хэмжээ зорилтот түвшнээ 100 хувь хангасан байна. 2024 онд 2.2 мянган тонн хүнсний ногоо хураан авсан нь суурь түвшнээс 300 тонноор нэмэгдсэн байна.

Аймгийн хэмжээнд 2024 онд 17500 жуулчин хүлээн авсан нь зорилтот түвшнээ бүрэн хангажээ.

Идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн тоо 1053-т хүрч өмнөх оноос нэмэгдсэн боловч “Ковид-19” цар тахлын улмаас аж ахуйн нэгжүүд үүд хаалгаа барьж, идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, байгууллагын тоо өмнөх онуудад буурсан тул зорилтот түвшиндээ хүрч чадаагүй байна.

Инженерийн бүрэн хангамжтай орон сууцаар хангагдсан өрх нийт өрхийн 7.4 хувьд хүрсэн нь өмнөх оноос өсөж, зорилтод түвшиндээ хүрсэн байна.

Аймгийн хэмжээнд цахилгаан эрчим хүчээр хангагдсан хүн амын эзлэх хувь 98.9 хувьд хүрч зорилтот түвшиндээ хүрлээ.

Хүн амын дундаж наслалт 74.37, хүний хөгжлийн индекс 0.745 хүрч, зорилтот түвшнээ хангаж, өмнөх оноос тус тус өссөн үзүүлэлттэй байна. Харин жендэрийн тэгш бус байдлын индексийг аймгийн хэмжээнд тооцоход учир дутагдалтай байгаа тул улсын хэмжээнд тооцсон 2023 оны үзүүлэлтийг авч үзлээ.



2024 онд бүртгэгдсэн гэмт хэргийн тоог бууруулахаар зорьсон ч зорилтот түвшиндээ хүрч чадаагүй байна. Харин гэмт хэргийн илрүүлэлт болон иргэдэд учирсан хохирлыг нөхөн төлүүлэлтийн түвшин нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Нарийн ширхэглэлт тоосонцор (PM2.5)-ын хэмжилтээр жилийн дундаж агууламж 2024 онд 43 мг/м.куб байгаа нь өмнөх оноос буурч агаарын чанарын MNS 4585:2016 стандартаас давж бохирдсон үзүүлэлт ажиглагдаагүй.

Аймгийн ойгоор бүрхэгдсэн талбайн эзлэх хувь өмнөх оноос 0.1 пунктээр нэмэгдэж, 2024 оны зорилтот түвшнээ хангасан байна.

Эрүүл мэндийн салбарын хувьд өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн хамрагдалтыг нэмэгдүүлж, зорилтот түвшнийг давуулан биелүүлсэн байна. Мөн 1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдлийн түвшин, 10000 хүн амд вируст гепатитын өвчлөл өмнөх оноос буурч, 100000 амьд төрөлтөт ногдох эхийн эндэгдлийн түвшин 0 промилль гэсэн эерэг үзүүлэлттэй байна.

Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын цэвэр жин 70.9 хувь, суурь боловсролын хамран сургалтын цэвэр жин 89.96 хувьд өмнөх оноос нэмэгджээ.

Элсэлтийн ерөнхий шалгалтын дундаж оноог дээшлүүлэхээр сургалт, зохион байгуулалтын арга хэмжээ авсны үр дүнд өмнөх оноос 4 оноогоор ахисан боловч зорилтот түвшиндээ хүрээгүй байна.

Аймгийн эдийн засгийн хөгжлийн 21 үзүүлэлт, нийгмийн хөгжлийн 24 үзүүлэлт, нийт 45 үзүүлэлтийн биелэлт 90.4 хувьтай байна.

Нийт 45 үзүүлэлтийн 36 үзүүлэлт нь 2024 оны зорилтот түвшинд хүрч, 8 үзүүлэлт нь 30.0-97.2 хувиар биелсэн байна. Харин PM10 тоосонцрын жилийн дундаж агууламжийг аймгаас гаргах боломжгүй байна.

Цаашид аймгийн хэмжээнд гаргах боломжгүй байгаа зарим тоон судалгааг хасаж тооцох шаардлагатай байна.



ХОЁР. БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ

2.1 Монгол Улсын Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт

2024 онд Монгол Улсын Засгийн газрын гишүүн 19 сайдаас аймгийн Засаг даргатай “Хамтран ажиллах гэрээ” байгуулан ажилласан ба гэрээний хэрэгжилтийг тайлагнаж, холбогдох яамдад хүргүүлсэн. Сайд нартай байгуулсан гэрээний үүргийн биелэлт дунджаар 93.0 хувьтай байна. (Хүснэгт 6.)

Хүснэгт 6. Гэрээний хэрэгжилтийн дүн

№	Аймгийн Засаг даргатай гэрээ байгуулсан сайд	Гэрээний хэрэгжилтийн хувь
1	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга	95.8
2	Монгол Улсын Шадар сайд	93.8
3	Хууль зүй, дотоод хэргийн сайд	94.3
4	Эдийн засаг, хөгжлийн сайд	95.0
5	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	90.04
6	Сангийн сайд	97.6
7	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд	97.2
8	Зам, тээврийн сайд	89.0
9	Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд	93.9
10	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд	91.8
11	Эрчим хүчний сайд	82.2
12	Боловсролын сайд	90.25
13	Эрүүл мэндийн сайд	94.0
14	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	92.0
15	Батлан хамгаалахын сайд	97.8
16	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд	98.3
17	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд	80.2
18	Гадаад харилцааны сайд	99.5
19	Олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хороо	94.3
Дундаж үнэлгээ		93.0

“Хамтран ажиллах гэрээ”-нд тусгагдсан зорилт, арга хэмжээг аймгийн Засаг даргын Тамгын газар, холбогдох хэлтэс, агентлагийн гүйцэтгэлийн төлөвлөгөө



болон сумын Засаг даргын гэрээнд тусгаж, удирдлага зохион байгуулалтаар ханган ажилласан.

Сайдуудтай байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-ний үр дүнг товч тайлагнаж байна.

Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга:

Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Булган аймгийн Засаг даргатай 2024 онд хамтран ажиллах гэрээнд 6 зорилт 31 арга хэмжээг хамтран хэрэгжүүлэхээр тусгасан.

2024 онд орон нутагт ажилладаг нутгийн захиргааны байгууллагын төрийн захиргааны албан хаагчдын орон нутгийн нэмэгдлийг 40 хувиар нэмэгдүүлэх, хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх, “Нээлттэй аймаг” хөтөлбөрийг хэрэгжүүлж орон нутагт шилжин суурьших иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг хүлээн авахад шаардагдах бэлтгэлийг хангах, төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, төрийн байгууллагад иргэдээс ирж байгаа өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн байдлыг сайжруулах зэрэг томоохон ач холбогдол бүхий зорилт, арга хэмжээнүүдийг амжилттай гүйцэтгэн, гэрээний хэрэгжилтийг 95.8 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлэн ажиллалаа.

Монгол Улсын Шадар сайд:

Монгол Улсын Шадар сайд, Булган аймгийн Засаг дарга нарын 2024 онд хамтран ажиллах гэрээнд 31 арга хэмжээг хамтран хэрэгжүүлэхээр тусган 93.8 хувьтай хэрэгжүүлэв.

Гамшгийн эрсдэлийг бууруулах, аймаг, сумдад гамшгаас хамгаалах иж бүрэн болон команд штабын сургууль, бэлэн байдлын үзлэг, ангиллын сургалт зохион байгуулах, гамшгаас хамгаалах, галын сайн дурын бүрэлдэхүүнийг сургаж дадлагажуулахад шаардагдах хөрөнгийг шийдвэрлэх, материаллаг баазыг нэмэгдүүлэх, мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр шаардлагатай арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх, Стандарт, хэмжил зүйн хэлтсийн албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах техник хэрэгслийг шинэчлэх зэрэг ажил, арга хэмжээг амжилттай хэрэгжүүлэн ажилласан.

Хууль зүй, дотоод хэргийн сайд:

Хууль зүй, дотоод хэргийн сайд, Булган аймгийн Засаг дарга 2024 онд хамтран ажиллах гэрээний хүрээнд 3 зорилтын 16 арга хэмжээг төлөвлөн ажилласан. Гэрээний хэрэгжилтийг 2024 оны жилийн эцсийн байдлаар тооцож үзэхэд 94.3 хувийн биелэлттэй дүгнэгдлээ.



Салбарын байгууллагуудын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор орон нутгаас 116.8 сая төгрөгийг шийдвэрлэсэн байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газраас Булган аймаг дахь Шүүхийн Тамгын газрын дэргэдэх “Ахмад хуульчдын холбоо”-ны ахмад хуульчид, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар, Булган аймаг дахь Прокурорын газар, Байгаль орчны газар, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газартай хамтран “Иргэдэд ойр эрх зүйн үйлчилгээ-2024” арга хэмжээг зохион байгуулсан. Уг арга хэмжээний хүрээнд 16 сум, 1 тосгоны Засаг дарга, тосгоны захирагчийн 1156 “А”, “Б” захирамж, Тамгын газрын даргын 816 “А”, “Б” тушаал, сургууль, цэцэрлэг, соёлын төв, эрүүл мэндийн төвийн захирал, эрхлэгчийн 647 “А”, “Б” тушаал, 37 төрийн болон төрийн өмчит байгууллагын 902 “А”, 1144 “Б” эрх зүйн акттай танилцаж, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн.

Хууль зүй, дотоод хэргийн яам, Булган сум дахь тойргийн нотариатч нартай хамтран аймгийн 15 сум, 1 тосгоны нотариатын үүрэг гүйцэтгэгч сумын Засаг даргын Тамгын газрын дарга, Хууль, эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд чадавхжуулах сургалтыг 2 удаа зохион байгуулсан.

2024 онд 4580 гэрээ хэлцэл, 1543 итгэмжлэл, 3428 хуулбар үнэн, 716 гарын үсгийн баталгаа, 268 өв залгамжлалыг гэрчлэн 10535 иргэнд нотариатын үйлчилгээ үзүүлсэн байна.

Эдийн засаг, хөгжлийн сайд:

Эдийн засаг, хөгжлийн сайд Булган аймгийн Засаг даргын хооронд 2024 онд хамтран ажиллах гэрээнд 3 зорилтын 13 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусган жилийн эцсийн байдлаар 95.0 хувьтай биелсэн байна.

“Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”, “Бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөр”-ийн төсөлд санал авах үеийн онуудад Булган аймгаас ажлын хэсэг гарч, сумд, агентлагаас саналыг авч нэгтгэн ИТХ-ын хуралдаанд танилцуулж, хэлэлцүүлэн хүргүүлсэн. Мөн 2024 оны 01, 02 дугаар сард 3 удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулагдаж, аймгаас холбогдох хүмүүсийг оролцуулж, аймгийн хэмжээний саналуудыг тусгуулахаар санал солилцож, 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 64 дүгээр тогтоолоор Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлагдсан.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд:

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Булган аймгийн Засаг даргын хооронд 2024 онд хамтран ажиллах гэрээнд 11 зорилтын 52 арга хэмжээг тусган хэрэгжүүлж, жилийн эцсийн байдлаар 90.04 хувьтай биелсэн байна.



Сангийн сайд:

Монгол Улсын Сангийн сайдтай 2024 онд “Хамтран ажиллах гэрээ”-нд тусгагдсан 49 арга хэмжээг 97.6 хувьтай биелүүлсэн.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль, түүний нэмэлт өөрчлөлтийн дагуу төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны төсвийг батлуулан санхүү, төсвийн бодлогын арга хэмжээг орон нутагт зохион байгуулах, нэгдсэн удирдлагаар хангах, зохицуулах үйл ажиллагааг гүйцэтгэж, хууль, журмын хэрэгжилтийг ханган ажилласан.

2024 онд орон нутгийн төсөвт 61.5 тэрбум төгрөгийн орлогыг бүрдүүлж төлөвлөгөөг 110.7 хувь, улсын төсөвт 3.1 тэрбум төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 112.7 хувиар биелүүлсэн. Аймгийн төсвийн нийт зарлага 99.3 тэрбум төгрөгөөр батлагдаж, гүйцэтгэлээр 86.4 тэрбум төгрөг гарч, төсвийн гүйцэтгэл 87.0 хувьтай гарсан.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд:

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Булган аймгийн Засаг даргын хооронд 2024 онд хамтран ажилласан гэрээнд 9 зорилтын 68 арга хэмжээг тусган жилийн эцсийн байдлаар 97.2 хувьтай биелсэн байна.

Цөлжилт газрын доройтолтой тэмцэх, ой мод, усны нөөцийг хамгаалах, экологийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор ойн хортон шавжийн тэмцлийн ажлыг зохион байгуулж, ойн хортон шавжийн үхэл 86.5-92.8 хувьтай хийгдлээ.

Ан агнуурын 2024-2028 оны менежментийн төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж батлууллаа. Ойжуулалт, нөхөн сэргээлт, ойг хамгаалах арга хэмжээнд 1921600.0 мянган төгрөг, усны нөөцийг хамгаалах арга хэмжээнд 39900.0 мянган төгрөг, биологийн төрөл зүйлийг хамгаалах арга хэмжээнд 74825.7 мянган төгрөг, орчны бохирдлыг бууруулах хог хаягдлыг багасгах арга хэмжээнд 1511000.0 мянган төгрөг тус тус зарцууллаа.

Зам, тээврийн сайд:

Зам тээврийн сайд Булган аймгийн Засаг даргын хооронд 2024 онд хамтран ажиллах гэрээнд 24 арга хэмжээг тусган хэрэгжүүлж, жилийн эцсийн байдлаар 89.0 хувьтай биелсэн байна.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд:

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Булган аймгийн Засаг даргын хооронд 2024 онд хамтран ажиллах гэрээнд 3 зорилтын 33 арга хэмжээг тусган жилийн эцсийн байдлаар 93.9 хувьтай хэрэгжүүлэн ажиллав.



Орон нутгийн хөгжлийн санд ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн 516.0 сая төгрөг төвлөрөн сумын бүтээн байгуулалтын ажилд зарцууллаа. Бүрэгхангай суманд уул уурхайн олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа тусгай зөвшөөрөл эзэмшигч “Өгөөж баянхангай” ХХК, “Платинум Ланд” ХХК, “Гэрэлт шинэчлэл” ХХК, “Хос хас” ХХК-тай нийгмийн хариуцлагын гэрээ байгуулж, хүүхдийн боловсролыг дэмжих асуудлаар 126.0 сая төгрөгийг аймгийн Засаг даргын Тамгын газрын нөөц хөрөнгөд төвлөрүүлсэн.

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд:

Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх чиг үүргийн дагуу 78 арга хэмжээг 2024 оны жилийн эцсийн байдлаар 91.8 хувьтай хэрэгжүүлэв. Үүнд: 100 хувьтай 60, 90 хувьтай 7, 70 хувьтай 5, 50 хувьтай 5, 0 хувьтай 1 арга хэмжээ байна.

Эрчим хүчний сайд:

Эрчим хүчний сайдтай байгуулсан 2024 оны хамтран ажиллах гэрээнд туссан 27 заалтын хэрэгжилт 82.2 хувьтай биелсэн бөгөөд сум суурин газрын цахилгаан эрчим хүчний шинэчлэлийн ажлыг 4 суманд хийж гүйцэтгэн, ашиглалтад оруулснаар аймгийн цахилгаан хангамжийн шугам сүлжээний найдвартай, тогтвортой ажиллагааг хангуулахад томоохон дэмжлэг болсон.

Боловсролын сайд:

Энэ хичээлийн жилд сургуулийн өмнөх боловсролд 3813, ерөнхий боловсролд 11457, насан туршийн суралцахуйн төвд 148, мэргэжлийн боловсролын сургуульд 576 суралцагчийг хамруулж, хичээл сургалтын үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулж байна.

Бага боловсролын математикийн EDUTEN, бага дунд ангийн англи хэлний PEARSON хөтөлбөрийг нийт сургуульд 100 хувь хэрэгжүүлэн ажиллаж байна. Мөн “after school”, “suraad.mn” платформуудыг ашиглан хичээлээс гадуурх сургалт үйл ажиллагаа болон математикийн хичээлийн сургалтын хоцрогдлыг нөхөх ажлыг хэрэгжүүлж байна.

Ерөнхий боловсролын сургууль төгсөгч, их, дээд сургууль, коллежид элсэх 526 суралцагчаас монгол хэл, бичгийн ерөнхий шалгалтыг авч 81.1 хувь нь тэнцсэн. Элсэлтийн ерөнхий шалгалтын хэмжээст онооны дундаж 509 буюу өмнөх жилээс 4 пунктээр өссөн. Боловсролын үнэлгээний төвөөс зохион байгуулдаг багшийн болон байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний сурагчдаас авсан бичгийн шалгалтын үнэлгээ 51.6 хувь буюу өмнөх оноос 4.5 хувиар ахисан байна.



Сургуулийн өмнөх насны 4524 хүүхдийн 3813 буюу 84.2 хувийг цэцэрлэгийн үйлчилгээнд хамруулж байгаа нь өмнөх онтой харьцуулахад 1.3 пунктээр ахисан байна. Үүнээс 5 настай хүүхдийн цэцэрлэгт хамрагдалт 87.5 хувьтай байна.

Ерөнхий боловсролын 22 сургуулийн 28 дотуур байрны орчин дахь хүүхэд хамгааллын баг 1927 эцэг, эхтэй гараас гарт гэрээг байгуулан сурагчдын дунд "Найз байя-2" аяныг зохион байгууллаа. Аянд 1-12 дугаар ангийн 3687 хүүхэд хамрагдаж, дотуур байрны орчинд хүүхдийг аливаа хэлбэрийн дарамт, хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалд өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 127 удаагийн сургалт нөлөөллийн үйл ажиллагааг олон талт хэлбэрээр зохион байгуулсан байна. Мөн хүүхэд гэр бүлтэйгээ холбоо барих боломжийг бүрдүүлэхээр "Итгэлтэй утас" үйл ажиллагааг зохион байгуулж аймгийн 19 сургуульд нээлттэй утас байршуулан сургуулийн нийгмийн ажилтан, эмч, дотуур байрын багш нарт цахим болон танхимын сургалт, зөвлөгөө, зөвлөмж өгч ажилласнаар сургуулийн орчин дахь үе дэнгийн дээрэлхэлт дарамттай холбоотой гомдлын тоо 40 хувиар буурсан.

Эрүүл мэндийн сайд:

Аймгийн хэмжээнд халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэг, шинжилгээ, оношилгоонд 26355 иргэн буюу хамрагдвал зохих хүн амын 44.3 хувийг хамруулсан нь улсын дунджаас 1.5 хувиар дээгүүр үзүүлэлттэй байна. Эрт илрүүлэг үзлэгээр хавдрын сэжигтэй, хавдрын урьдал, үүсгэвэр, уйланхай, урагцаг, чулуу, үрэвсэлтэй 318 тохиолдлыг дээд шатлалын эмнэлэгт илгээж, 51 тохиолдлыг эмчилгээнд хамруулан, эмчийн хяналтад авлаа. Амны хөндийн эрүүл мэндийн үзлэгт 16872 хүүхдийг хамруулахад ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын 75 хувь, цэцэрлэгийн хүүхдүүдийн 66 хувьд шүд цоорох өвчлөл илэрсэн бөгөөд тэдгээрийн 40 хувийг бүрэн эмчилсэн.

Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр 728 удаагийн танхимын сургалтад 14300 иргэнийг хамруулж, 14 төрлийн 12600 санамж, 6 төрлийн 4621 зурагт хуудас, давхардсан тоогоор нийт 16 мянга гаруй зөвлөмж, зурагт хуудас, гарын авлагыг иргэд, олон нийтэд түгээсэн.

“Шүд угаах цаг” зохион байгуулах зөвлөмж бичлэгийг “Сайхан Монгол” телевизтэй хамтран бэлтгэж, цахим сургалтыг эрүүл мэндийн байгууллагын дарга, нийгмийн ажилтан, ерөнхий боловсролын сургуулиудын захирал, нийгмийн ажилтан, эмч нарт зохион байгуулсан.

Аймгийн хэмжээнд 2024 оны жилийн эцсийн статистик мэдээгээр 1-5 насны хүүхдийн эндэгдлийн 5 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 1.1 промилль



ногдож байна. Нялхсын эндэгдлийн 5 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 10.6 байгаа нь өмнөх оны мөн үеэс 54.5 хувиар буурсан эерэг үзүүлэлттэй байна.

Төгсөлтийн дараах үндсэн мэргэжил олгох сургалтад 4 их эмч, төрөлжсөн мэргэшил олгох сургалтад 3 их эмч, 4 сувилагч, мэргэжил дээшлүүлэх сургалтад 5 эмнэлгийн тусгай мэргэжилтэн хамрагдсан. Мөн аймгийн хэмжээнд давхардсан тоогоор 1400 эмнэлгийн мэргэжилтэн ажлын байрны давтан мэргэшүүлэх сургалтад, 15 мэргэжилтэн гадаад сургалтад хамрагдаж байна.

Төрийн албан хаагчдын давтан мэргэшүүлэх багц цагийн сургалтад 320 эмнэлгийн мэргэжилтэн хамрагдаж, нийгмийн эрүүл мэндийн магистрын зэрэг горилох сургалтад 2 мэргэжилтэн, төрийн албанд анх томилогдсон сургалтад 2, дунд хугацааны давтан сургалтад 1 төрийн захиргааны албан хаагч хамрагдсан.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд:

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын төсвийн ерөнхийлөн захирагч болон Булган аймгийн Засаг даргын хооронд Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний 5 зорилтын 24 арга хэмжээг 92.0 хувьтай хэрэгжүүлэн ажиллалаа.

2024 онд шинээр 117 аж ахуйн нэгж, байгууллагыг нийгмийн даатгалын шимтгэл төлөгч байгууллагаар бүртгэн авч, албан журмын даатгалд хамрагддаг аж ахуйн нэгж байгууллагын тоо 796 болж нэмэгдсэн. Тус байгууллагуудад 9378 даатгуулагч ажиллаж байна.

Аж ахуйн нэгж, байгууллагуудын нийгмийн даатгалын шимтгэлийн өр авлагыг барагдуулах ажлын үр дүнд авлагын хэмжээ суурь түвшнээс 50.4 хувиар буурч, зорилтот түвшний 84.4 хувийг биелүүлсэн.

“ХАЛАМЖААС-ХӨДӨЛМӨРТ” зорилтын хүрээнд зорилтот бүлгийн хөдөлмөрийн насны гишүүдэд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, хөдөлмөрт бэлтгэх, ажилд зуучлах, төсөл, хөтөлбөрт хамруулж, өрхийн орлогыг дэмжих, бүх гишүүдэд боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээг хүргэж, амьжиргааг цогцоор нь дэмжин ажилласнаар байнгын ажлын байранд 49, түр ажлын байранд 268, мэргэжил олгох сургалтанд 33 иргэнийг тус тус хамруулж, нийт 317 иргэний хөдөлмөр эрхлэх, орлогоо нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлэв.

Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний бүлгийн төсөлд 141 иргэн, онцгой тохиолдлын мөнгөн тэтгэмжид 13 иргэнийг хамруулан орон нутгийн төсвөөс 108.8 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, амьжиргааг нь дэмжсэн.



Аймгийн хэмжээнд гэр бүл дэх хүчирхийллийг бууруулах, урьдчилан сэргийлэх зорилгоор "Хүүхэд хөгжил, хамгааллын хөтөлбөр"-ийг 4 зорилтын 12 үйл ажиллагаагаар төлөвлөн бүрэн хэрэгжүүлэн ажиллалаа. Гэр бүлийн боловсрол олгох сургалтаар 16 сум, 1 тосгонд тус бүр 2 удаа хүрч ажиллан 32 удаагийн сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 6634 иргэнийг хамруулсан нь өмнөх онтой харьцуулахад хамрагдалт 2 дахин их буюу аймгийн нийт өрхийн 34 хувийг эзэлж байна. Эдгээр ажлуудын үр дүнд жилийн эцсийн байдлаар хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийн дуудлага 172 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 33 хувиар буурсан эерэг үзүүлэлттэй байна.

“Жаргалант” хүүхдийн зуслангийн гал тогоо, хоолны зал, сургалтын танхим бүхий захиргаа удирдлагын байрны барилгын ажлыг дуусгаж ашиглалтад оруулснаар хүүхэд хөгжлийн зуны хөтөлбөрийг хэрэгжүүлэн Булган, Орхон, Хөвсгөл аймгийн нийт 168 хүүхэд хүлээн авч ажилласан.

Монгол Улсын залуучуудын өдрийг тохиолдуулан үндэсний хэмжээнд зохион байгуулдаг “Эх оронч залуу” аяны хүрээнд 1890 хүүхэд залуучууд, Монгол Улсын Ерөнхий сайдын ивээл дор жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Иргэний андгай өргөх ёслол”-ын арга хэмжээнд аймгийн 16 сум, 1 тосгоны 16 нас хүрч буй 1123 хүүхэд “Иргэний андгай” өргөн иргэний үнэмлэхээ гардан авч, дээрх 2 үйл ажиллагаанд 3013 өсвөр үе залуучуудыг хамруулсан.

Батлан хамгаалахын сайд:

Монгол Улсын Засгийн газрын батлан хамгаалах зарим чиг үүргийг Булган аймагт төлөөлөн 2024 онд хэрэгжүүлэх 5 зорилт, 33 арга хэмжээг 97.8 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд:

"Бүх нийтийн соёлын боловсрол олгох" хөтөлбөрийн хүрээнд 4 зорилт 24 арга хэмжээ бүхий төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг 90.0 хувь ханган ажиллалаа.

Аймгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөөнд туссан соёлын салбарын тоног төхөөрөмж, техник хэрэгсэл нийлүүлэхэд 732.0 сая төгрөг, 4 байгууллагын барилга, тайз, орон нутаг танхимын их засварт 1 тэрбум төгрөгийн эх үүсвэр шийдвэрлүүлж, хэрэгжүүлэв.

Соёлын нөөц, орон зайд тулгуурлан соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор "Байгальд ээлтэй аялал жуулчлалыг хөгжүүлцгээе" уриан дор “Айраг фестиваль 2024” эвент арга хэмжээг зохион байгуулж, 17500 гаруй жуулчид хүрэлцэн ирж, үзэж сонирхсон байна.



Аймгийг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн хүрээнд буриад үндэстний соёлыг сурталчлах, бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх, буриад дуу, бүжиг, гар урлал, өв уламжлалыг сурталчлах зорилгоор “Алтаргана 2024” олон улсын XV их наадмыг зохион байгуулж, соёл, спорт, хэвлэл мэдээллийн чиглэлээр зохион байгуулагдсан 22 төрлийн тэмцээн уралдаанд 1700 гаруй иргэд авьяас, мэдлэг, ур чадвараа сорин оролцлоо. Тус наадмын тэмцээн уралдаан болон соёлын цогц арга хэмжээг гадаад, дотоодын 60 гаруй мянган жуулчид үзэж сонирхлоо.

Соёл Урлагийн Их сургуультай хамтран ажиллах гэрээ байгуулж, элсэлтийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, 5 хүүхдэд аймгийн Засаг даргын нэрэмжит тэтгэлэг олгосон. Аймгийн соёл урлагийн салбарт ажиллаж байгаа албан хаагчдын мэргэжлийн хүний нөөцийн хангалт өмнөх оноос 2.7 пунктээр нэмэгдэж, 68.2 хувьд хүрсэн байна.

Театр, соёлын ордны дэргэд хүүхдийн авьяас чадварыг хөгжүүлэх 21 төрлийн дугуйланд давхардсан тоогоор 2220 хүүхэд хамрагдаж урлагийн боловсрол эзэмшиж байна.

Олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хорооны дарга:

“Биеийн тамир, спортыг хөгжүүлэх хөтөлбөр”-т орон нутгийн төсвөөс 150.0 сая төгрөг, “Өсвөрийн шигшээ багийг бэлтгэх хөтөлбөр”-т 90.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж, улс, бүсийн чанартай тэмцээн уралдааныг аймаг орон нутагтаа амжилттай зохион байгууллаа.

Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх чиглэлээр аймгийн хэмжээнд 63 багш дасгалжуулагчийн удирдлага дор 23 төрлийн секц дугуйланд 3124 хүүхэд тогтмол хичээллэж байна.

Өсвөрийн шигшээ багийг бэлтгэх хөтөлбөрийн хүрээнд шигшээ багийг 12 төрлөөр байгуулж, бэлтгэл сургуулилт, хэрэглэл материал, тэмцээний зардалд орон нутгийн төсвөөс 32.3 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Улс, бүс, олон улс, аймаг орон нутгийн чанартай 54 удаагийн тэмцээн уралдаанд өсвөрийн 2478 тамирчин оролцож, 332 медаль хүртэж, үзүүлсэн амжилт өмнөх оны мөн үеэс 14 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

2022 онд 2 суманд, 2024 онд 4 суманд арга зүйчийг томилон ажиллуулаад байна.

2024 онд олон улсын тэмцээнээс 4, Ази тив болон дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс 13, улсын аварга шалгаруулах тэмцээнд 189 тамирчин медальт байрт шалгарснаар аймгийн хэмжээнд журмын болзол хангасан 206 тамирчин, 8 дасгалжуулагчид 88.8 сая төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон.



“Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний хүрээнд өглөөний алхалт, гүйлт, гимнастик, нийтийн шугаман бүжиг, явган аялал, сагсан бөмбөг, дугуйн уралдаан болон волейбол, сур харваа, усан спорт, боксын арга хэмжээг тус тус зохион байгуулан 27000 мянга гаруй иргэд, хүүхэд, залуучууд хамрагдлаа. Мөн “Эрчимтэй жин хаях” дасгал хөдөлгөөнөөр 100 гаруй иргэд тогтмол хичээллэж, “Зөв хооллолт ба өглөөний дасгал” сэдвээр сургалт, заавар зөвлөгөө өгч ажиллав.

2024 онд Улс, бүсийн чанартай 3 төрлийн уралдаан тэмцээнийг зохион байгуулан орон нутгийн төсвөөс 52.6 сая төгрөг зарцууллаа. Монгол Улсын гавьяат дасгалжуулагч Г.Баатар агсны нэрэмжит өсвөрийн цанын улсын аварга шалгаруулах тэмцээнд 15 багийн 126 тамирчин, Самбо бөхийн олон улсын хэмжээний мастер, дасгалжуулагч Н.Мөнхөө агсны нэрэмжит самбо бөхийн өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээнд 32 багийн 420 гаруй тамирчин, Л.Дорж агсны нэрэмжит зуун буудалт даамны улсын аварга шалгаруулах тэмцээнд 17 багийн 180 гаруй тамирчид өрсөлдсөн.

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд:

Булган аймгийн Засаг дарга болон Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны хооронд 2024 онд хамтран ажиллах гэрээнд 3 зорилт 36 арга хэмжээг 80.2 хувьтай хэрэгжүүлэв.

Төрийн цахим үйлчилгээний “Хурдан” төвийг бүх суманд операторын горимоор нэвтрүүлж, киоск төхөөрөмжийг байршуулсан.

Цахим гарын үсгийн тухай хууль болон "Цахим Монгол" төрийн үйлчилгээг орон нутагт үр дүнтэй хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2024 онд аймгийн хэмжээнд 30844 иргэн, 16 сумын 345 аж ахуйн нэгж, байгууллагад тоон гарын үсэг олгосон байна.

2024 онд харилцаа холбооны үүргийн сангийн 720.0 сая төгрөгөөр 5 байршилд үүрэн холбооны антен барьж ашиглалтад оруулан алслагдсан багийн иргэдийг төрийн үйлчилгээг цахимаар авах нөхцөлийг бүрдүүллээ.

Гадаад харилцааны сайд:

Хамтран ажиллах гэрээнд аймгийн Засаг даргын хэрэгжүүлэх 11 арга хэмжээ тусгаснаас 10 арга хэмжээ 100 хувийн хэрэгжилттэй буюу Монгол Улсын гадаад харилцааны “Нэг цонх”-ны бодлого, холбогдох хууль тогтоомжийг чанд баримтлан ажилласан байна.

Найрсаг харилцаа бүхий БНСУ-ын Кёнги аймагтай боловсрол, эрүүл мэндийн салбарын хамтын ажиллагаа, ОХУ-ын Буриад улстай соёл, боловсролын салбарын хамтын ажиллагаа идэвхтэй хэрэгжүүлсэн.



**ДӨРӨВ. БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН (2024 ОН)**

Үзүүлэлт		Хувь	Жин	Оноо
1	2	3	4	5
Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ	1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт	93.41	0.5	2.3
	2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	91.1		
	3. Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт	88.07		
	4. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	91.9		
	5. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлт	90.4		
Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	1. Монгол Улсын Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт	93.0	0.15	0.7
	2. Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт	90.77		
	3. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилт	95.71		
Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	1. Байгууллагын ил тод байдал	96.59	0.2	0.9
	2. Шилэн дансны хөтлөлт			
	3. Шударга байдлын түвшин			
	4. Хэрэглэгчийн үнэлгээ			
Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн үнэлгээ	1. Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээг үнэлэх шалгуур үзүүлэлтийн биелэлт	82.2	0.15	0.6
Ерөнхий үнэлгээ:				4.5

ТАЙЛАН НЭГТГЭСЭН: ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ

ХЭЛТСИЙН ДАРГА

Ч.ЦОГБУЯН

ХЯНАСАН: АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.НАРАНБАЯР

ТАНИЛЦСАН: АЙМГИЙН ЗАСАГ

ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР